УЛС ТӨР
Шинээр сонгогдсон гишүүд үнэмлэхээ гардлаа → 2

НИЙГМИЙН СОНИН
Малайзад хүний наймааны золиос болсон монгол охид эсэн мэнд олджээ → 3

ШИНЖЛЭХ УХААН
Коронавирусийг хагас минутын дотор устгах арга нээжээ → 15

ZGM DAILY
FULL ENGLISH PAGE INSIDE → 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2020.06.30, МЯГМАР~№114 (1393) ~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~ ₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,784.40 0.33%	5,957.00 1.09%	610.00 6.15%	41.01 0.02%	100.45	108.85	101.04	100.64	2,822.98	398.85	40.35	2.35

ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ҮНЭ ХОЁР ДАХИН НЭМЭГДЛЭЭ

Шинэ ургац гарахаас өмнө төмс, хүнсний ногооны үнэ нэмэгддэг ч сүүлийн таван жилд одоогийнх шиг хоёр дахин нэмэгдэж байсангүй

Гэрэл зургийг С.Батсайхан

→ 6

Үндсэн хууль, парламентын эрхийн дээгүүр гишгэлсэн шийдвэрт ямар хариу барих вэ → 7

Халдашгүй байдлыг үл тоон хорьдог буруу жишиг Ж.Эрдэнэбатаар дуусгавар болоосой.

Хямралаас гарахын тулд Монгол Улс ОУВС-д дахин хадаг барих уу → 8

Засаглалын хямралд гүн зоогдсон Монгол Улс эдийн засгийн хямралд улам гүнзгий шигджээ.

Халуухан цоолборч А.Анужин → 17

#269 $6.43 тэрбум

Хавьер Ниел,
Free Mobile-ийн үүсгэн байгуулагч, Францын тэрбумтан

Үргэлж үр өгөөжтэй хөрөнгө оруулалт хийхэд анхаарч, боломжийг эрэлхийл.

Өнөөдөр	Маргааш
24°C	23°C
12°C	12°C

8 658000 029112 01393

УЛС ТӨР

ПАРЛАМЕНТ

Шинээр сонгогдсон гишүүд үнэмлэхээ гардлаа

Б.Энхжаргал, ЗГМ сонин

Гэрэл зургийг ЗГМ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд ялалт байгуулсан 76 нэр дэвшигч Төрийн ордны Их танхимд Монгол Улсын Их Хурлын гишүүний үнэмлэхээ гардан авлаа.

СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн энэ үеэр, "Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн дүнг нэгтгэн, 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, тойрогт нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан мандатын тоотой тэнцүү 76 нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож, тогтоол гаргалаа" хэмээв.

Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолын дагуу тойрог тус бүрээр гишүүдийн нэрсийг дуудаж, үнэмлэх болон СЕХ-ны тогтоолыг гардуулан өгсөн юм.

Ийнхүү 76 шинэ гишүүн үнэмлэхээ гардан авсны дараа Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Улсын Их Хурлын даргад өргөн барьсан юм. ■

НАМУУД

Томсгосон мажоритар тогтолцооны сул тал асар их байна

П.Наранбаяр: Надад итгэж саналаа өгсөн 23,479 хүний санал гээгдчихлээ

"Зөв хүн электорат" эвслээс УИХ-ын сонгуулийн үр дүнгийн талаар байр сууриа илэрхийлэхдээ "мажоритар тогтолцоо сонгогчдын саналыг ихээр гээгдүүлдэг болох"-ыг тодотгов.

Тухайлбал, УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойрогт "Зөв хүн электорат" эвслээс нэр дэвшсэн Б.Мөнхсоёл "Томсгосон мажоритар тогтолцоо нь маш олон сул талтай. Энэ тогтолцоонд танигдаагүй улстөрч, улс төрийн хүчин өрсөлдөхөд бэрх байдаг. Сонгуулийн кампанит ажлын 22 хоногийн хугацаанд ард түмэндээ хүрч ажиллах боломж тун бага. Түүнчлэн улс төрийн намууд төлөвших боломжгүй болох буюу нэг намынхан хүртэл хоорондоо өрсөлдөх магадлалтай болдог" гэлээ. Харин 22 дугаар тойрог буюу Баянзүрх дүүрэгт тус эвслээс нэр дэвшсэн П.Наранбаяр "Надад 22 дугаар тойргийн 23,479 хүн саналаа өгчээ. Итгэж саналаа өгсөн баянзүрхчүүддээ талархаж байна. Гэвч тэдний энэ их санал гээгдчихлээ. Энэ бол томсгосон мажоритар тогтолцооны сул талын илрэл боллоо" гэв. ■

ТОМИЛГОО

УИХ-ын дэд даргад Ц.Туваан, бүлгийн даргад Ж.Сүхбаатарын нэр яригдаж байна

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламент бүтцийн байгууллагуудаа шинэчлэх гэж байна. УИХ-ын гишүүн бүр 2-3 байнгын хороонд харьяалагдах бөгөөд, найм болон түүнээс дээш суудалтай намууд бүлэг байгуулж, УИХ-ын дэд дарга томилох эрхтэй. Энэ дагуу УИХ-д Ардчилсан нам болон Монгол Ардын Намын бүлэг байгуулагдаж, мөн тус бүлгээс нэг нэг дэд даргыг томилно.

Эрх баригч МАН-ын хувьд эхлээд Засгийн газрыг байгуулах ажлыг шуурхайлахыг зорьж байгаа бол сөрөг хүчин АН бүлгийн дарга, дэд дарга улмаар Улсын Их Хурлын дэд даргад хэнийг томилох вэ гэдгийг яриад эхэлжээ.

Эх сурвалжуудын мэдээлж буйгаар УИХ-ын дэд даргад, Төв аймгаас УИХ-ын гишүүнээр сонгогдсон Ц.Тувааны нэр яригдаж байгаа аж.

Ц.Туваан одоогоор Ардчилсан намын даргын үүргийг гүйцэтгэж байгаа юм. Тэгвэл бүлгийн даргад Сүхбаатар аймгаас сонгогдсон Ж.Сүхбаатар, Ховдын Б.Пүрэвдорж нарын нэр яригдаж эхэлжээ. Б.Пүрэвдорж бүлгийн дэд даргаар ажиллаж байсан туршлагатай ч, дотроо гишүүдээ зангидаж, гаднаа УИХ дахь бүлгийн байр суурийг илэрхийлэхэд Ж.Сүхбаатар илүү тохиромжтой гэж үзэх нь байна. ■

ЭШЛЭЛ

Миний бие 2016 оноос хойш Швейцарийн прокурорт гурван жил шалгагдаж, мөн Монголын АТГ, Хонгконгийн хуулийн байгууллага, АНУ гээд би дэлхийгээр шалгуулсан. Олон улсын гэмт хэрэгт холбогдуулан намайг гүтгэсэн хүмүүсийн үйлдэл удаа дараа давтагдаж байгаа учраас би хуулийн байгууллагад шалгуулахаар өгч байна. С.Баярцогтыг шалгаж байх хугацаанд Английн тагнуул, Монголын АТГ шалгаж намайг холбоогүй гэдгийг нотолсон. Мөн намайг С.Баярцогтын дансанд хахууль өгсөн гэх зүйлийг ярьсан. Би 2004 онд уул уурхайн бизнест хөл тавихад С.Баярцогт ямар нэг албан тушаалгүй байсан. Тухайн үед улсын хөрөнгөөр нэг ч өрөм тавиагүй, стратегийн хэмжээний нөөцгүй байсан гэсэн шалтгаануудаар стратегийн ордод оруулаагүй.

УИХ-ын гишүүн
Б.Дэлгэрсайхан

ЗГМ: ТОВЧХОН

▪ ТОО

91.7

Хувь. УИХ-ын сонгуулийн есөн тойрогт МАН үнэмлэхүй ялалт байгуулсан. Нийслэлд нэр дэвшсэн 24 нэр дэвшигчээс 22 нь ялалт байгуулсан буюу 91.7 хувийн амжилт үзүүлсэн байна. Энэ нь өмнө гарч байгаагүй өндөр хувьтай үзүүлэлт аж.

СУРГАЛТ

Шинээр сонгогдсон гишүүдэд түр үнэмлэхийг нь олгосны дараа Улсын Их Хурлын тамгын газраас анх удаа сонгогдсон гишүүдэд тусгайлан "хичээл" заав. Энэ удаагийн парламентад шинээр сонгогдсон 32 гишүүн байгаа бөгөөд тэдэнд УИХ-ын үйл ажиллагаа, дүрэм журам, гишүүний ёс зүй, парламентын хянан шалгах үүрэг болон УИХ-ын цалин, хангамжийн талаарх мэдээллийг өгөх сургалт хийсэн юм.

Малайзад хүний наймааны золиос болсон монгол охид эсэн мэнд олджээ

Малайзад барьцаалагдсан монгол эмэгтэйг зодож, хүнд гэмтэл учруулжээ

Т.Намуун, ЗГМ сонин

Малайз улсад хүний наймаа, хүчин зэрэг онц аюултай гэмт хэргийн золиос болж байсан монгол охидын нөхцөл байдлын талаар манай сонин мэдээлж байсан билээ. Тус улсын хамгаалах байранд 11 монгол хүн байгаагаас Малайзын цагдаад хүчирхийлүүлсэн гэх хоёр эмэгтэй болон хүний наймаанд өртсөн байж болзошгүй зургаан эмэгтэй байсан юм. Мөн манай улсын иргэн хоёр монгол эмэгтэй ор сураггүй алга болж, ар гэрийнхэн нь олон сарын турш хайж байв. Тэгвэл ор сураггүй алга болсон дээрх хоёр эмэгтэйг эсэн мэнд олсон бөгөөд бусдад барьцаалагдаж, дарамтлуулж байсан нь тодорхой болжээ. Одоогоор нэгнийх нь биеийн байдал хүндэвтэр байгаа бөгөөд тус улсын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна. Удаан хугацаанд барьцаалагдаж байсан хоёр эмэгтэйн нэг нь тус улсад нуугдаж, аюулгүй байдлаа хангахын тулд хүнд нөхцөлд амьдарч байсан бөгөөд удаа дараа хүсэлт илгээж, чартер нислэгт багтсан боловч консулын ажилтан хохирогчийн ар гэрийнхэнд "Тусгай нислэгийн зардлыг яамнаас төлнө" хэмээн ташаа мэдээлэл өгч онгоцноос нь хоцроосон аж.

Харин хамгаалах байранд байсан 11 монгол иргэний гурав нь чартер нислэгт багтан эх орондоо ирсэн бөгөөд тэд хүний наймааны золиос болж байжээ. Тэднийг Монгол дахь ТББ болон Малайзын өргөмжит консулын тусламжтай хамгаалах байранд хүргэж байв. Одоогоор Малайз улсын цагдаад хүчирхийлүүлсэн хоёр монгол эмэгтэй хамгаалах байранд амьдарч буй бөгөөд ирэх сарын 8-нд болох шүүх хурлаа хүлээж буй. ■

> **МАНАЙ УЛСЫН ИРГЭН ХОЁР МОНГОЛ ЭМЭГТЭЙ ОР СУРАГГҮЙ АЛГА БОЛЖ, АР ГЭРИЙНХЭН НЬ ОЛОН САРЫН ТУРШ ХАЙЖ БАЙВ. ТЭГВЭЛ ОР СУРАГГҮЙ АЛГА БОЛСОН ДЭЭРХ ХОЁР ЭМЭГТЭЙГ ЭСЭН МЭНД ОЛСОН БӨГӨӨД БУСДАД БАРЬЦААЛАГДАЖ, ДАРАМТЛУУЛЖ БАЙСАН НЬ ТОДОРХОЙ БОЛЖЭЭ.**

Хөвсгөлийн наадамд найман насны морьд уралдана

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Үзэгчгүй, урлаг соёлын хөтөлбөргүй, цомхон ч гэсэн монгол наадам болдгоороо болно. Бөхчүүд, харваачид бэлтгэлдээ гарч, уяачид хурдан хүлгийнхээ уяа сойлгыг тааруулж байна. Энэ жилийн гол онцлог нь коронавирусийн цар тахлын улмаас улс, аймаг, сумын наадам бүгд долдугаар сарын 11, 12-нд болох журам тогтсон. Тэгвэл Хөвсгөл аймгийнхан л зургаа биш найман насны морьд уралдуулах сурагтай. Тэд шүдлэн, хязаалан, соёолон, азарга, их нас, дааганаас гадна эрлийз дунд, бага насны морины уралдаан зохион байгуулах гэнэ. Хоёр өдөрт наадмаа багтаах тус аймгийн хурдан морины уралдаан их л шахуу хуваарьтай болох нь. Харин бусад аймагт зургаан насны морьд уралдана.

Үүнээс гадна зарим аймгийн баяр наадам хаалттай болох сурагтай. Өөрөөр хэлбэл, бусад аймгийн бөхчүүдийг нутгийнхаа наадамд оролцуулахгүй аж. Уржигдар аймгийн наадмын бүртгэл дууссан. Бүртгэлийн үеэр хэд хэдэн аймагт ийм асуудал гарчээ. Шалтгаан нь аймгийн наадамд 128 бөх барилдуулах болсонтой холбоотой аж. ■

The HU хамтлагийн тоглолтын үеэр ^53 сая цугларчээ

Өнгөрсөн ням гарагт The HU хамтлагийн Улсын онцгой комисст хандив өргөх "ГЭРЭГ" тоглолт болсон билээ. Энэхүү тоглолтын үеэр нийт 53 сая төгрөг цугларсан ба хандивыг шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулж Улсын Онцгой комисст хандивлах аж. Тус хандивын тоглолт White Rock Center-т болсон бөгөөд тоглолтыг The HU хамтлаг "Хүрээ энтертайнмент" ХХК-тай хамтран MYOHPT-ээр шууд дамжуулан хүргэж, ивээн тэтгэгчээр Мобиком корпораци, Хаан банк ажилласан юм. ■

Парист байрлах монгол хөшөө

Үзэсгэлэнт Парис хотод орших Сорбонне их сургуулийн өмнө байрлах том биетэй эрийг дүрсэлсэн уран баримал цахим орчинд багагүй шуугиан дэгдээв. "Монгол зогсолт" гэх тайлбартай эл хөшөөг Хятадын уран барималч Шэнь Хунбяо 2009 онд Сорбоннийн их сургуульд докторын ажил хамгаалсныхаа дараа нөхөрлөлийн илэрхийлэл болгож бэлэглэсэн байна. Энэхүү хөшөө анх Фарис хотын Соуффлотын гудамжинд байрладаг байжээ. Тус баримлыг бүтээсэн Шэнь Хунбяо энэ хэв загвараар хэд хэдэн бүтээл хийсэн алдартай уран барималч бөгөөд Монголд зочилж байжээ. ■

Наадмын нээлтээр Их Монгол улсын үеийг харуулна

Ардын хувьсгалын 99 жилийн баяр наадам болоход 11 хоног үлджээ. Өчигдөр Үндэсний баяр наадмыг зохион байгуулах комисс хуралдахдаа орон нутгийн наадмыг үзэгчдэд нээлттэй болгосон байна. Тодруулбал, аймаг, сумын наадмыг үзэгчид үзэх нь нээлттэй бөгөөд энэ үеэр амны хаалт зайлшгүй зүүх гэнэ. Мөн халдвар, хамгаллын өндөр хяналт дор орон нутагт худалдаа, үйлчилгээ явуулах ч эрх олгох юм байна. Харин улсын баяр наадмыг "XIII зуун" цогцолборт явуулах хэвээрээ бөгөөд дэд бүтцийн ажил бүрэн дуусжээ. Наадмын нээлтийг "Херо" энтертайнментын найруулагч Б.Баатар найруулахдаа монголчуудын төрт ёсны уламжлал, үүх түүх, эрийн гурван наадам, ард иргэдийн хувцас хэрэглэлийн соёл, ахуй нөхцөл, гэр бараа зэргийг Их Монгол Улсын үеийнхээр дэглэн үзүүлэх гэнэ. ■



ГАЗРЫН ТӨЛБӨР ИХ ХЭМЖЭЭГЭЭР НЭМЭГДСЭНИЙГ ИРГЭД МЭДЭЭГҮЙ БАЙНА

Нийслэлд газрын төлбөрийн орлого 2017 оныхоос хоёр дахин нэмэгдэж 64.4 тэрбумд хүрчээ

Б.Гарьд, ЗГМ сонин

УИХ, Засгийн газар коронавирусийн цар тахлын улмаас орлого нь буурсан аж ахуй нэгж, иргэний орлогын татвар болон Нийгмийн даатгалын шимтгэлийг зургаан сараар тэглэсэн. Энэ "өршөөл" үр дүнгээ өгч хувийн хэвшил, түүнд ажиллагсдын орлого тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь сайшаалтай. Харин **аж ахуй нэгжүүдэд газрын төлбөр төвөг учруулж мэдэхээр байна. Энэ нь Засгийн газраас баталсан газрын үнэлгээний тойрог, бүс, төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тогтоолтой холбоотой.** Засгийн газар 21 жилийн дараа төрийн, нийтийн өмчид хамаарах газрын төлбөрийг нэмсэн нь энэ бөгөөд улсын төсвийн орлогыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх зорилготой юм.

Засгийн газраас 2018 онд баталсан тус тогтоолоор аймаг, нийслэлийн төвийн болон бэлчээрийн газрыг үнэлж төлбөрийг нэмж тогтоосноос гадна уул уурхай, аялал жуулчлал гээд бүхий л салбарын бизнест хамаарах газрын төлбөрийг нэмсэн. Тухайлбал, **1997 оноос нийслэлийн газрыг таван бүс, 10 төрлөөр тогтоож нэг ам метр газарт 440 төгрөгийн төлбөр авч байсан бол 2018 оноос эхлэн бүс, төрлийн тоог нэмсэн юм. Үүний дагуу аймаг, дүүргүүдийн ИТХ тогтоол гаргаж, газрын албадаас газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, бүсийн хил хязгаарыг баталжээ.** Нийслэлд л гэхэд төвийн зургаан дүүргийг 16 бүс, Налайх дүүргийг 12, Багануурыг ес, Багахангайг хоёр бүстэй байхаар тогтоож, газар эзэмшигч, ашиглагч нийт 21 мянга орчим иргэн, хуулийн этгээдийн гэрээг шинэчилж, газрын төлбөрийг нэмэгдсэн дүнгээр авч байгаа юм.

УИХ-аас 2020 оны төсвийн тухай хуулийг батлахдаа Засгийн газраас өргөн барьсан газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, ААН-ийн газрын төлбөрийн орлогыг бүрэн хураадаг болох зорилтыг дэмжсэн. Энэ хүрээнд газрын төлбөрийн орлогоор 107.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх учиртай. Тэр дундаа нийслэлийн бүсээс нийт орлогын хагасыг буюу 48.5 тэрбум төгрөг хуримтлуулахаар хуульчилсан юм. Тухайлбал, Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газар 77.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс газрын төлбөрөөр 48.5 тэрбум, үлдсэнийг нь газрын дуудлага худалдаанаас олохоор төсөвлөжээ.

Газрын төлбөрийг нэмэгдүүлсэн дүнгээр авах болсноор хувийн хэвшил, иргэдийн орлогоос тодорхой хэмжээгээр хасагдах нь ойлгомжтой. Харин энэ талаар олон нийт бага мэдээлэлтэй байсан нь хүндрэлийн энэ үед мэдрэгдэж эхэлжээ. Тэр дундаа нийслэлд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэд, аж ахуй нэгжийн эздэд илүүтэй мэдрэгдэж байгаа аж. Мөн зуслангийн газар эзэмшигч иргэд төлбөр яагаад нэмэгдсэн талаар газрын албаныхныг байцаах болжээ.

Нийслэлийн газрын бүсийн үнэлгээ
(сая төгрөг)

Газрын үнэлгээний бүсийн дугаар	Гэр бүлийн хамтын хэрэгцээ	Худалдаа бүх төрлийн үйлчилгээ	Бүх төрлийн үйлдвэрлэл
1-5	382-818	1,088-1,280	1,216-1,408
6-10	109-273	896-960	1,024-1,152
11-16	18-55	192-768	76-960

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛ АМЖТАЛ ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТӨД ХАМРУУЛБАЛ НҮДЭЭ ОЛСОН АЛХАМ БОЛНО.

Засгийн газраас баталсан тогтоолоор **нийслэлийн төвийн зургаан дүүргийн газрын бүсчлэл, үнэлгээг тогтоохдоо иргэдийн эзэмшиж буй зуслангийн газрыг бүсээс хамаарч 18-818 сая төгрөг, ААН-ийн эзэмшиж, ашиглаж буй газрын төлбөрийг бүс болон төрлөөс хамаарч 192 саяас 1.4 тэрбум төгрөгөөр үнэлсэн байгаа. ААН-ээс авах газрын төлбөрийг аймаг дүүргийн ИТХ-аас баталдаг учир харилцан адилгүй. Харин иргэний эзэмшиж буй зуслангийн газарт төлбөр ноогдуулахдаа 90 хувийг нь хөнгөлж 10 хувьд нь татвар авч байгаа аж.** Зуслангийн газар эзэмшиж буй иргэн бүсийн үнэлгээний дагуу 10 хувийн төлбөрийг жил бүр төлнө. Энэ нь 15 жилээр үржвэл чамгүй мөнгө болох юм.

Нийслэлд эзэмшүүлсэн газраас 48 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төсөвлөжээ.

Мөн хүснэгтээс харвал нийслэлд газар эзэмшиж буй үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж газрын төлбөр өндөр дүнтэй төлөхөөр байна. Үүний цаана хувийн хэвшлийн орлогоос чамгүй мөнгө зулгаах нь тодорхой байгаа юм. Жишээлбэл, нийслэлийн нэгдүгээр бүс буюу хотын төвд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж эзэмшиж, ашиглаж буй газартаа нэг метр тутамд 1096 төгрөг төлнө. 100 метр квадрат буюу 10 мянган метр газрын төлбөрт 10 сая төгрөг төлөх юм. Бизнесийн орлого нь буурсан, ажилчдынхаа цалинг арай ядан төлж байгаа аж ахуй нэгжид энэ хэмжээний мөнгө газрын төлбөрт өгнө гэдэг хүндрэлтэй. Газар эзэмших нийт хугацаагаар тооцвол дунджаар 200 гаруй сая төгрөгийг төлөх нь бизнесийн үр ашигт ч муугаар нөлөөлж мэдэх юм.

Хэдийгээр татварын байгууллага газрын төлбөрөө төлөхийг шаналгаж эхлээгүй боловч төсвийн орлогоо биелүүлэхийн тулд шаардах нь тодорхой. **Өмнөх онуудад газрын төлбөрийг тухайн орон нутгийн газрын алба төвлөрүүлдэг байсан боловч өнөө жилээс татварын байгууллага авахаар болжээ. Энэ нь иргэн, ААН-ийг улсад өр төлбөртэй гэдгийг тодорхойлох хэмжүүр болох юм. Цаашилбал иргэн, аж ахуй нэгжид бас нэг дарамт болох нь ойлгомжтой байна.**

Тиймээс коронавирусийн эдийн засагт үзүүлж буй хүндрэл, иргэн, аж ахуй нэгжийн орлогын бууралт зэргийг харгалзан эдийн засаг сайжирч хүндрэлээс гартал газрын төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх



Гэрэл зургийг С.Батсайхан

шийдвэр гаргавал нүдээ олсон шийдвэр болохыг хэн хүнгүй хэлж байгаа юм. Тэгээд ч сая МАН-ын сонгуулиар дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрт орсон заалтуудтай уялдах учраас хэрэгжүүлэх боломжтой. Тухайлбал, “Үндэсний аж үйлдвэрийн салбараа хөгжүүлж, 150,000 ажлын байр шинээр бий болгоно”, “COVID-19 цар тахлаас үүдсэн нийгэм, эдийн засгийн хүндрэлийг арилгах,үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг сэргээх тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, орлогын хомсдолд орсон аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдийн амьжиргааны орлогыг нөхөх арга хэмжээ авна” гэсэн заалтуудтай бүрнээ нийцнэ. Мөн хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулдаггүй юм гэхэд ажил үйлчилгээгээр солих боломж ч



байгаа. МАН 2020 оны мөрийн хөтөлбөртөө нийслэлийн Богд хан уул, Баянзүрх, Сонгино, Чингэлтэй, Дамбадаржаа хайрхан, тахилга шүтээнт уул толгодын орчныг иргэд, төр хувийн хэвшлийн түншлэлээр ойжуулахаар тусгасан. Энэ ажлын хүрээнд иргэн, аж ахуй нэгжийг газрын төлбөрөөс чөлөөлж, ойжуулах ажлыг орлуулж болох юм. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: XVII.1.168 “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 10 ор /Архангай, Ихтамир сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: ЭМЯ/202001024

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос XVII.1.168 “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 10 ор /Архангай, Ихтамир сум/” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер иргүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.0 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Багцгүй.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна.

Ижил төстэй ажилд барилга угсралтын ажил гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл иргүүлэх эсэх: Тийм

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа иргүүлнэ. 10,000,000.00 (арван сая) төгрөг

Тендерийг 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд иргүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 10 минутад Төрийн худалдан авах ажиллагааны газарт нээнэ.

Гадаадын этгээд тендер иргүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn цахим хуудаснаас бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А, ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260115, 260056, Цахим хаяг: www.tender.gov.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: XII.1.1.229 “Сургуулийн барилгын өргөтгөл /Хэнтий, Баян-Адрага сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.
Тендер шалгаруулалтын дугаар: БСШУСЯ/202001036

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос XII.1.1.229 “Сургуулийн барилгын өргөтгөл /Хэнтий, Баян-Адрага сум/” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер иргүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Багцгүй.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл иргүүлэх эсэх: Тийм

Барилга хот байгуулалтын яамны

-БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

- БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,

- БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,

- БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

- БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

- БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил.

Түншлэлийн гишүүн бүр тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа иргүүлнэ. 15,000,000.0/Арван таван сая/ төгрөг.

Тендерийг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 12.00 цагаас өмнө системд иргүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 12.10 цагт Төрийн худалдан авах ажиллагааны газарт нээнэ.

Гадаадын этгээд тендер иргүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn цахим хуудаснаас бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А, ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 263022, 260115, Цахим хаяг: www.tender.gov.mn

ЗГМ: ТОВЧХОН

ЭРҮҮЛ МЭНД

Энэ сарын 28-ны өдөр 216 хүнд шинжилгээ хийхэд нэг хүнээс нь коронавирус илэрч, нийт батлагдсан тохиолдол 220 боллоо. Энэ сарын 10-нд Нур Султан-Улаанбаатар чиглэлийн онгоцоор ирсэн нэг хүний гурав дахь давтан шинжилгээгээр ийнхүү коронавирус илэрчээ.

ДУУДЛАГА

ТЦА-ны Жижүүрийн шуурхай удирдлагын хэлтэст өнгөрсөн амралтын өдрүүдэд 506 дуудлага мэдээлэл хүлээн авснаас 316 нь зам тээврийн ослын шинжтэй байжээ. Тус ослын улмаас 11 хүн гэмтсэн бөгөөд эдгээрийн дөрөв нь хүүхэд байсан аж.

МЭДЭГДЭЛ

Цахим орчинд ирэх долоодугаар сарын 07-ны өдрөөс орон нутгийн чиглэлийн замын хөдөлгөөнийг хаана гэсэн ташаа мэдээлэл гарсантай холбогдуулан ЗТХЯ-наас мэдэгдэл гаргажээ. Уг мэдэгдэлд "УОК-оос баяр наадмын амралтын өдрүүдээр орон нутаг руу чиглэсэн улсын чанартай авто замуудыг хаах, хөдөлгөөнийг хязгаарлах талаар шийдвэр гаргаагүй болохыг авто зам хэрэглэгч, зорчигч та бүхэнд мэдэгдэж байна" гэжээ.

НИЙСЛЭЛ

Нийслэл хотын нийтийн тээврийн Таван шар-Офицерийн ордны чиглэлд өнөөдрөөс эхэлж, хоёр давхар автобусыг үйлчилгээнд гарахаар шийдвэрлэжээ. БНХАУ-аас авч буй 50 ширхэг хоёр давхар автобус нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд ийнхүү шат дараатай явж эхлэх аж.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Өчигдөр Ховд аймгийн төвд тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгджээ. Тухайн сэжигтэй тохиолдолтой 50 гаруй хүн нэгдүгээр хавьтал болсон бол 400 гаруй хүн хоёрдугаар хавьтал болсон аж. Сэжигтэй тохиолдол хэмээн бүртгэгдсэн 27 настай залуугийн биеийн байдал маш хүнд байгаа гэнэ.

Төмс, хүнсний ногооны үнэ хоёр дахин нэмэгдлээ

Шинэ ургац гарахаас өмнө төмс, хүнсний ногооны үнэ нэмэгддэг ч сүүлийн таван жилд одоогийнх шиг хоёр дахин нэмэгдэж байсангүй

Г.Санжааханд, ЗГМ сонин

Өнгөрсөн амралтын өдрүүдээс зарим худалдааны зах болон супермаркетууд нэг кг төмсийг 2500 төгрөгөөр борлуулсан нь иргэдийг ихээхэн бухимдуулав. Төмс, хүнсний ногооны үнэ хэрхэн нэмэгдсэн талаар сурвалжлахаар Бөмбөгөр худалдааны төвийг зорилоо. Эгнэн өрсөн төмс болон бусад хүнсний ногооны үнийг хэд хэдэн удаа өөрчилсөн бололтой балалж, сохолсон байсан юм. Тухайлбал, төмс 2500 төгрөг байсныг 2000 болгожээ. Лууван 2200 төгрөг байсныг 2000 болгосон бол хүрэн манжинг 500 төгрөгөөр бууруулан 3000 төгрөг болгожээ. Өнгөрсөн амралтын өдөр төмс болон бусад хүнсний ногооны үнэд ийнхүү өөрчлөлт орсон хэмээн тус төвийн худалдагч нар хэлэв.

Бөмбөгөр худалдааны төвөөр үйлчлүүлэх 40 гаруй насны эмэгтэй "Амралтын өдөр нэг кг төмс 2500 төгрөгийн үнэтэй байсан. Өнөөдөр (өчигдөр) хүнсний ногооны үнэ 200-500 төгрөгөөр буурсан байна. Дахиад буурах байх гэсэн хүлээлттэй байгаа учраас их хэмжээгээр авалгүй, боломжийнхоо хэрээр бага багаар авч байна. Коронавирусээс болоод иргэдийн худалдан авалт муу байхад үнээ нэмж байгаад бухимдаж байна" хэмээлээ. **Тус төвд монгол төмс 2000, лууван 2000, байцаа 2500, сонгино 5000, шар манжин 6000-7000 төгрөг болсон байв.** "Тариалан эрхлэгчдийн зооринд хадгалсан төмс, хүнсний ногоо дуусах дөхөж байгаа учраас үнэ нь ийнхүү нэмэгдсэн. Шинэ ургацын ногоо гарахаас өмнө жил бүр үнэ нэмэгддэг нь бичигдээгүй хууль шүү дээ. Тэгэхээр гайхах зүйл байхгүй" хэмээн Бөмбөгөр худалдааны төвийн худалдагч Г.Чимгээ хэлсэн юм.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс болон зарим хүнсний ногооны үнэ хоёр дахин нэмэгдсэн байлаа. Тэр ч байтугай нэг сарын өмнөхөөс ч хоёр дахин нэмэгдсэн байсан юм. Тухайн үед төмс 900, манжин 2500, сонгино 1500 төгрөгөөр худалдаалж байсан гэх үнийн мэдээллийг Нийслэлийн статистикийн газраас гаргажээ. Шинэ ургац гарахаас өмнө төмс, хүнсний ногооны үнэ жил бүрийн өдийд нэмэгддэг хэдий ч сүүлийн таван жилд одоогийнх шиг хоёр дахин нэмэгдэж байгаагүйг тоо баримтаас харж болохоор байлаа.

Харин Хүчит шонхор захад төмс, хүнсний ногооны үнэ Бөмбөгөр худалдааны төвтэй адил байсан ч монгол гэх тодотголтой сонгино арай хямд буюу 2000-3500 төгрөг байсан юм. Тус захын худалдагч М.Сарнай "Өнгөрсөн амралтын өдрүүдэд төмс болон бусад хүнсний ногооны үнэ нэмэгдсэн. **Шинэ ургац гараагүйтэй холбоотой үнийн хөөрөгдөл үүсэж байна. Цаашид үнэ нь улам нэмэгдэнэ гэх яриа гарсан.** Бид 100-200 төгрөг л нэмж зарж байгаа. Төмс цаанаасаа ирэхдээ 1800 төгрөгөөр ирсэн. Гэтэл хүмүүс биднийг үнээ нэмсэн юм шиг буруутгаж, уурлах юм. Хаягдал их байдаг болохоор ашиг олоход ч хэцүү байдаг" хэмээн учирлалаа.

Хүчит шонхор захад хятад хүнсний ногоо зардаг лангуу цөөхөн харагдана. Хятад гэх тодотголтой төмс, лууван, байцаа, сонгино бүгд 1500 төгрөгийн үнэтэй байсан юм. Тус лангууны худалдагч бүсгүй **"Хөл хорионоос болоод хятад ногоо орж ирэх нь багассан. Гэтэл монгол ногооны үнэ нэмэгдсээр байна. Наадам өнгөртөл энэ байдал үргэлжилнэ гэсэн. Худалдан авалт үнэхээр муу байна.** Гэхдээ өдөр тутмын хэрэглээ болохоор бага ч гэсэн орлого оруулж байгаад талархах нь зүйтэй байх" гэв.

2018 онд 2,888 тонн төмс импортоор оруулж ирж байсан бол өнгөрсөн онд 381 тонн болж, 2020 оны эхний таван сарын байдлаар 4.3 тонныг л оруулж ирснийг Гаалийн ерөнхий газрын мэдээлэлд дурджээ. Үүнтэй холбоотойгоор хүнсний ногооны үнэ нэмэгдэж байгаа гэх хардлага байна. Учир нь манай улс дотоодынхоо хэрэглээний 40 хувийг л хангаж чаддаг. Үлдсэн 60 хувийг импортын хүнсний ногоо орлодог. Гэтэл хөл хорионоос болж импортын хэмжээ буурсан тул дотоодынхоо хэрэглээг хангаж чадахаа больж, үнийн хөөрөгдөл үүсгэж байна. Ногоочдоо дэмжихийн тулд энэ онд хүнсний ногооны гаалийн татварыг 30 хувь болгох тогтоол гарч, ирэх наймдугаар сарын 1-нээс дагаж мөрдөхөөр болсон. Энэ шийдвэр сайшаалтай хэдий ч ийнхүү хориг тавих нь хэр зөв болохыг холбогдох албан тушаалтнууд нь эргэн харах буй за. ■

Гэрэл зургийг С.Батсайхан

Төмс, хүнсний ногооны үнэ
(Төгрөг)

2019.06.29		2020.06.29
1000	Төмс	2000
1500	Лууван	2000
2500	Манжин (шар)	7000
	(хүрэн)	3000
2500	Байцаа	2500
1500	Сонгино	2000-5000

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

ЗГМ: ТОДРУУЛГА

Б.Халиун: Унаач хүүхдүүд амны хаалттай уралдана

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Үндэсний их баяр наадмын үеэр хурдан морины уралдааны хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллах талаар өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ үеэр тус газрын дэд дарга Б.Халиунтай цөөн хором ярилцав.

-Энэ жил хурдан морины уралдааны хүүхдүүдэд ямар шаардлага тавьж байгаа вэ?

-Уяачид морьдоо бүртгүүлэхээр ирэхдээ уралдаанч хүүхдээ заавал эцэг, эхтэй нь хамт дагуулж ирнэ. Ингэснээр тухайн хүүхэд хурууны хээгээ уншуулж өөрийгөө баталгаажуулснаар нэгдсэн мэдээллийн санд бүртгэл нь орох юм. Мөн уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамруулсан гэрээг авчирна. Бүх унаач хүүхдүүд амны хаалтаа зүүх ёстой. Энэ жилийн баяр наадам улсын хэмжээнд нэг өдөр зохион байгуулагдах учраас 21 аймаг, есөн дүүрэг рүү тусгай цахим бүртгэлийн төхөөрөмжийг хүргүүлсэн. Бүртгэл өнөөдрөөс (өчигдрөөс) эхэлж байгаа бөгөөд ирэх долдугаар сарын 9-нийг хүртэл үргэлжилнэ. Унаач хүүхдүүд хамгаалалтын хувцас, хэрэглэл, өмсөөгүй, бүртгэлийн картгүй ирсэн бол уралдуулахгүй.

-Уяач хүүхдийн гэнэтийн ослын даатгалд өөрчлөлт орсон гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Энэ жилээс тухайн уралдаанч хүүхэд бүтэн жил даатгалд хамрагдах боломжтой болж байгаа. Даатгалд хамрагдах суурь хураамж нь 100 мянга, нөхөн олговрын хэмжээ нь 20 сая төгрөг байна. Тухайн даатгал нь дан ганц уралдааны явцад бус бүтэн жил үйлчилнэ.

Даатгалын хувьд санхүүгийн зохицуулах хорооноос 11 даатгалын компани бүртгэлтэй байгаагаас одоогоор дөрвөн даатгалын компанитай хамтарч ажиллаж байна. Даатгалын нөхөн олговрын хэмжээг ихэсгэснээр өнгөрсөн онд 121 хүүхэд 186.6 сая төгрөгийн гэнэтийн ослын даатгалын нөхөн олговор авсан. ■

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Б.Энхжин, ЗГМ сонин

Гэрэл зургийг Жаргалтулгын Эрдэнэбатыг дэмжигчид фэйсбүүк хуудас

Үндсэн хууль, парламентын эрхийн дээгүүр гишгэлсэн шийдвэрт ямар хариу барих вэ

Халдашгүй байдлыг үл тоон хорьдог буруу жишиг Ж.Эрдэнэбатаар дуусгавар болоосой

УИХ-д сонгогдсон эрхмүүд өчигдөр Төрийн ордонд гишүүний түр үнэмлэхээ ёслол төгөлдөр гардаж авлаа. Уг нь 76 гишүүн үнэмлэхээ авах ёстой байсан ч нэг нь ирж чадсангүй. Тэр бол хорих 461 дүгээр ангид саатуулагдаж буй Ж.Эрдэнэбат гишүүн. Сонгуулийн өмнөхөн, бүр тодруулбал зургадугаар сарын 12-нд түүнийг Ерөнхий сайд байхдаа үйлдсэн гэх хэрэгт нь холбогдуулан цагдан хорьсныг бид мэднэ.

СЕХ-ны даргын тайлбарласнаар бол гишүүний үнэмлэхийг заавал өөрт нь гардуулж өгөх ёстой тул хэн нэгэнд дайх боломжгүй гэнэ. Тэгэхээр СЕХ-ны төлөөлөл хорих ангид очих уу, эсвэл Ж.Эрдэнэбат гишүүнийг суллах уу гэдэг нь сонирхол татаж байна. Нэгэнт гишүүнээр сонгогдсон юм чинь яаж ийж байгаад үнэмлэхийг нь өгөх байлгүй дээ.

Ер нь энэ жилийн сонгууль хорих ангиас зургаан хүн нэр дэвшин өрсөлдөж, нэг нь ялалт байгуулсан гэдгээрээ түүхэнд үлдэх байх.

Уг нь сонгуульд нэр дэвшигчийг баривчлах, хорих тохиолдолд заавал СЕХ-ноос зөвшөөрөл авна гэх хуулийн өөрчлөлтийг парламент өнгөрсөн жил УИХ-ын сонгуулийн тухай хууль батлахдаа оруулсан. Харин шүүх өөрийн шийдвэрээ "Нэр дэвшихээс өмнө мөрдөн байцаалт, прокурорын шатанд эрүүгийн хэрэг үүсгэж, түүнтэй холбоотой мөрдөн байцаалтын ажиллагаа нэгэнт явагдаж дуусан, шүүхэд хэрэг нь шилжиж ирсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэн явагдаж байгаа нэр дэвшигчийн хувьд хууль хэрэгжүүлэгчид урьд эхэлсэн ажиллагаандаа зөвшөөрөл авах асуудлыг зохицуулаагүй" хэмээн тайлбарласан.

Ийм тайлбараар таван нэр дэвшигчдийг хорьсон шалтгаанаа зөвтгөдөг юм байж. Тэгвэл бүрэн эрх нь хэвээр байгаа УИХ-ын гишүүнийг хорьсон нь хуулийг жинхэнэ утгаар нь уландаа гишгэсэн үйлдэл болсон. **Энд Ж.Эрдэнэбат аль нам, ямар фракцын гишүүн гэдэг хамаагүй. Хэрэг хийсэн, эсэх нь ч дараагийн асуудал. Харин Монгол Улсын Үндсэн хууль болон УИХ-ын тухай хуулийн дээгүүр гишгэж, парламентын гишүүнийг баривчлах, цагдан хорих хязгаарыг давсанд л гол учир бий.** Тухайлбал, Үндсэн хуулийн 29-р зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална" хэмээн заажээ. Мөн УИХ-ын тухай хуульд "Гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор УИХ-д оруулсан, гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг УИХ-д оруулсан тохиолдолд бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ" хэмээсэн байна. Ийм тодорхой заалтууд байсаар атал УИХ-ын гишүүнийг баривчилж байгаа нь шүүх төрийн эрх барих дээд байгууллагын эрхэнд халдаж буйг тодорхойлчихож байгаа хэрэг биш үү. Цаашилбал хуулиар хамгаалагдсан хүн, дархлагдсан бүрэн эрхт этгээдийг чингэж "элэг барьж" чадаж байгаа юм чинь жирийн иргэдийг яадаг бол гэсэн айдсыг ч төрүүлэх нь лавтай.

Нөгөөтэйгүүр **гишүүнээ өмгөөлж, бүрэн эрхийг нь хамгаалах ёстой УИХ, СЕХ таг чиг өнгөрсөн нь тун ч буруу жишиг тогтох үндэс болчихлоо. Энэ янзаараа бол дургүй хүргэсэн гишүүнээ барьж аваачаад хорьчихвол хэн ч өмгөөлж хамгаалдаггүй тийм тогтолцоо бүрдэхэд гайхах зүйл алга.** Хэрэв хууль, шүүхийнхэн тийм л эрхтэй юм бол УИХ-ын гишүүний халдашгүй байдал гэдэг хамгаалалтаа авч хаявал таарна.

Энэ талаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан маш ойлгомжтой тайлбарласан. Тэрбээр " Шүүх нь хараат бусаар ажиллах боломж хязгаарлагдмал өнөөгийн нөхцөлд УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг сулруулчихвал түүнийг улс төрийн явцуу сонирхлоор ашиглаж, парламентыг тогтворгүй байдалд оруулах магадлалтай. УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг өндрөөр хамгаалсан хууль нь өөрчлөгдөөгүй байхад шүүх түүнийг үл тооно гэдэг бол байж боломгүй" хэмээн ярилцлагадаа өгүүлжээ.

Үүнийг бичихдээ Ж.Эрдэнэбат гишүүнийг онцгойлон үзэж, өмгөөлж, хамгаалах гэсэнгүй ээ. Аль намын гишүүн байх нь ч чухал биш гэдгийг дээр өгүүлсэн. Түүний оронд Дорж, Дондогийн хэн ч байлаа гэсэн асуудлыг хуулийн дагуу л шийдэх ёстой гэсэн санаа юм. Хэрэв ийм л үед буруу эсэргүүцэж, дуугарахгүй бол цаашид хэн дуртайгаа барьж хорьдог буруу жишиг тогтчих гээд байна. **Санаачилсан хуулийг нь дэмжихгүй бол "барьж хорьчиход ядах юм байхгүй шүү" гэж шантаажлаад л хэргээ бүтээдэг болно гэсэн үг. Уг нь ийм эрсдэл бий болгохгүйн тулд л УИХ-ын гишүүний халдашгүй байдал гээчийг гаргаж ирсэн гэж боддог юм.**

> **ЭНД Ж.ЭРДЭНЭБАТ АЛЬ НАМ, ЯМАР ФРАКЦЫН ГИШҮҮН ГЭДЭГ ХАМААГҮЙ. ХЭРЭГ ХИЙСЭН, ЭСЭХ НЬ Ч ДАРААГИЙН АСУУДАЛ. ХАРИН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ХЯЗГААРЫГ ДАВСАНД Л ГОЛ УЧИР БИЙ.**

Харин одоо шүүхийнхэн энэ бүх бантангаа яаж цэвэрлэх гэж байгаа юм бол. Нэгэнт УИХ-ын гишүүнээр дахин сонгогдчихсон юм болохоор үргэлжлүүлэн хориод байж чадахгүй байх. Тэгэхээр шинэ парламент бүрдсэний дараа бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал оруулах биз. Хэрэв тэр үед УИХ хүсэлтийг нь хүлээн авбал бүх зүйл зөв голдрилдоо орох учиртай. **Хууль тогтоох дээд байгууллагаас ч дээгүүр эрх мэдэл эдэлж, дуртай хүнээ барьж хорьдог буруу жишиг Ж.Эрдэнэбатаар дуусгавар болоосой билээ. Мөн Үндсэн хууль, парламентын дээгүүр гишгэлсэн хуулийнхан энэ үйлдэлдээ хариуцлага хүлээх нь зүйд нийцнэ.**

Харин хамгийн түрүүнд дуугарах ёстой, гишүүнийхээ эрхийг хамгаалах учиртай УИХ-ын дарга Г.Занданшатар болоод гишүүд нь бүлх залгисан мэт чимээгүй өнгөрөв. Ангийнх нь нэгэн баригдахад дуугүй өнгөрсөн УИХ-ын гишүүд өөрсдийнх нь ээлж ирэхэд яах бол. Хаа очиж түүнтэй нэг тойрогт өрсөлдсөн эсрэг намынх нь нэр дэвшигч С.Баярцогт баривчилгааг буруушааж, өрсөлдөгчөө өмөөрч харагдана лээ. Эр хүн гэж магтъя. ■

ЭДИЙН ЗАСАГ

Энэтхэгийн сая сая ажилчин дүрвэж байна 11

3-5 дугаар сарын хооронд Энэтхэгийн мега хотуудаас 10 сая орчим хүн гадагш дүрвэжээ.

Цар тахал хүнсний хэрэглээг өөрчиллөө 11

ХБНГУ даяар үндсэндээ 200 мянга орчим цагаач ажилчдад тулгуурлан ажилладаг мах боловсруулах үйлдвэрүүдийг хаахаар төлөвлөж байна.

ЗГМ: ТОВЧХОН

▪ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж даваа гарагийн үнэт цаасны арилжаагаар 27 компанийн 397,125 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 14 компанийн хувьцааны ханш өсөж, найман компанийнх буурав.

▪ ИНДЕКС

2.46

Хувь. ТОП 20 индекс 0.23 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.46 их наяд төгрөг боллоо.

▪ ДУУДЛАГА ХУДАЛДАА

59.6

Сая ам.доллар. Төв банк гадаад валютын ээлжит дуудлага худалдаагаар өнгөрсөн долоо хоногт нийт 59.6 сая ам.доллар валют арилжааны цахим талбарт нийлүүлжээ.

▪ ИНФЛЯЦ

3.3

Хувь. Улсын хэмжээнд хэрэглээний үнийн индекс буюу инфляц 3.3 хувьтай байна.

▪ ХӨРШ

6.1

Хувь. ОХУ-ын ажилгүйдлийн түвшин тавдугаар сард 6.1 хувьд хүрлээ.

▪ ТӨЛӨВ

Morgan Stanley хөрөнгө оруулалтын банк дэлхийн эдийн засгийн өсөлт огцом унаж, энэ оны дөрөвдүгээр улирлаас хурдтай сэргэх төсөөллийг танилцууллаа.

▪ АНУ

750

Тэрбум ам.доллар. АНУ-ын Холбооны нөөцийн банк эдийн засгаа дэмжих үүднээс компаниудын бондыг худалдан авч эхэлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 750 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөжээ.

▪ БНХАУ

10

Хувь. Хятадын жижиглэн худалдааны салбар дахь худалдаа нэмэгдэж, үүнээс хэрэглээний үндсэн бүтээгдэхүүнүүд тавдугаар сард өмнөх оны мөн үеэс 10 гаруй хувиар өсөж, хүлээлтээс давлаа.

ХЯМРАЛААС ГАРАХЫН ТУЛД МОНГОЛ УЛС ОУВС-Д ДАХИН ХАДАГ БАРИХ УУ

Засаглалын хямралд гүн зоогдсон Монгол Улс эдийн засгийн хямралд улам гүнзгий шигджээ

Б.Баяртогтох, ЗГМ сонин

Засаглалын хямралд гүн зоогдсон Монгол Улс эдийн засгийн хямралд улам гүнзгий шигджээ. Хэзээ эндээс гарах эсэхийг өөрсдөө хэлж мэдэхгүй болтлоо доройтсон байна. **Тамирдсан эдийн засаг, тал хувь нь зогссон хувийн хэвшил өнөөдрийн бодит байдал, үнэн төрх билээ. Цалингаа тавьж чадахгүй аж ахуйн нэгжүүд дор бүрнээ тэвдэж, зарим нь өр зээлийн дарамт руу "гулсжээ".** Ам.долларын эсрэг төгрөгийн ханш монгол төрийн өнөөдрийн үнэлэмж шиг суга доошилсон байна. Төв банкны зарласан албан ханшаар ам.доллар 2821 төгрөгтэй тэнцэв. Түүхэнд байгаагүй ханш зах зээл дээр тогтож, төрийн сан хоосорч байна. Төсвийн алдагдал 1.6 их наядыг давлаа.

Ам.долларын ханш
(төгрөгөөр)



Эх сурвалж: Монголбанк

Улсын гадаад валютын албан нөөц тасралтгүй буурч, валютын ханшийн огцом хөдөлгөөнийг төв банк захирч дийлэхгүй алдлаа. Төгрөгийн ханш сулрах хэрээр түмний амьдрал дордож, ядуурал хүрээгээ тэлсээр. Монгол Улсын гурван хүн тутмын нэг нь ядуу байна. Улс орны нийгэм, эдийн засгийн тэнцвэр болсон дундаж давхарга хумигдаж, ажилгүй, орлогогүй болсон хүмүүсийн тоо өдөр өдрөөр нэмэгдсээр байгаа.

Тусгай хөтөлбөрт дахин хамрагдвал төсөв, мөнгөний бодлогыг У.Хүрэлсүхийн Засгийн газар, төв банк бус ОУВС тодорхойлно.

Он гарснаас хойш гэхэд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын судалгаагаар 40 гаруй мянган хүн ажлын байр алджээ. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.1 хувь давж, уг үзүүлэлтээрээ хөгжиж буй Азийн орнуудыг манай улс тэргүүллээ.

Улсын гадаад өрийн хэмжээнд гэхэд сүүлийн нэг жилийн хугацаанд 939.3 сая ам.доллар буюу 3.2 хувиар өсжээ. Тодруулбал, Засгийн газрын нийт энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр зээлийн дарамт, төсвийн алдагдал талийж өгснийг энэхүү статистик гэрчилнэ. Эдийн засаг муудах тусам бизнесийн орчин эмх цэгцээ алдаж, хөрөнгө оруулалт Монголоос дайжиж эхэлсэн. **Тодруулбал, он гарснаас хойш томоохон төсөл, хөтөлбөр дагасан хөрөнгө оруулалт төлбөрийн тэнцэл дээр бичигдсэнгүй. Дийлэнх төслүүд гацаж, зарим нь үйл ажиллагаагаа түр царцаажээ. Тухайлбал, Газрын тос боловсруулах үйлдвэр болон "Оюутолгой" төслийн гүний уурхайн бүтээн байгуулалт удааширч, төлөвлөгөөт ажлууд хойшлох нь тодорхой болов.**

Манай улс ирэх дөрвөн жилийн хугацаанд нэмж өр тавихгүй бол нийт 15 тэрбум ам.долларын

ЗАСАГЛАЛЫН ХЯМРАЛД ГҮН ЗООГДСОН МОНГОЛ УЛС ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛД УЛАМ ГҮНЗГИЙ ШИГДЖЭЭ. ХЭЗЭЭ ЭНДЭЭС ГАРАХ ЭСЭХИЙГ ӨӨРСДӨӨ ХЭЛЖ МЭДЭХГҮЙ БОЛТЛОО ДОРОЙТСОН БАЙНА. ТАМИРДСАН ЭДИЙН ЗАСАГ, ТАЛ ХУВЬ НЬ ЗОГССОН ХУВИЙН ХЭВШИЛ ӨНӨӨДРИЙН БОДИТ БАЙДАЛ, ҮНЭН ТӨРХ БИЛЭЭ. ЦАЛИНГАА ТАВЬЖ ЧАДАХГҮЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮД ДОР БҮРНЭЭ ТЭВДЭЖ, ЗАРИМ НЬ ӨР ЗЭЭЛИЙН ДАРАМТ РУУ "ГУЛСЖЭЭ".

гадаад өр болон түүний хүүгийн төлбөрийг барагдуулахаар байгаа. Энэ нь одоо байгаа гадаад валютын албан нөөцийн хэмжээнээс дөрөв дахин давсан дүн. Өрийг өөрийн хурааж, хуримтлуулсан валютаар төлөх боломж манай улсад байхгүй. Байх боломж хэдий байсан боловч нийгмийн хавтгайруулсан халамж, төсвийн үрэлгэн зардал болгоод салхинд хийсгэчихсэн. Тиймээс өрийг өрөөр санхүүжүүлэх л хувилбар байна. Гэхдээ олон улсын зах зээлээс хямд зардалтай мөнгө босгоно гэдэг мөрөөдөл болж мэдэх юм. Хөрөнгө оруулалтын томоохон сангуудын итгэлийг олох улам амаргүй байна.

Монгол Улсад итгэж, найдах хөрөнгө оруулагч үндсэндээ алга болсон. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд байсан жаахан итгэлийг нь эрх баригчид дэвсэлж орхисон. Одоо үүнийхээ горыг амсаж байна. Ам.долларын ханшийн өсөлтөөр монгол өрх болгон буруу бодлогын үр дүнг хүртэж буй. Эдийн засаг оны эхний улиралд 10.7 хувиар агшсан. Цаашид ч уналт, агшилт хувь хүний санхүүд хүртэл хүчтэй мэдрэгдэх төсөөллийг зарим судалгааны байгууллага гаргажээ. Төв банк төгрөг хэвлээд, хэрэглээг дэмжих замаар эдийн засгаа дэмжиж болно. Гэхдээ өнөөдрийн валютын ханшийн өндөр эрсдэл, гадаад өрийн дарамтаа харахаар энэ арга нь амиа хорлох хэмжээний үйлдэл болохоор байна.

Удаах нь экспортоо нэмэгдүүлэх замаар төсвийн орлогоо дорвитойхон ахиулах. Гэвч төмөр замгүй, дэд бүтэц нь хэдэн зуунаар хоцорсон улс хагас жилийн хугацаанд 42 сая тонн нүүрс экспортолж, эдийн засгаа аварна гэдэг үлгэр биз ээ. Эцсийн боломж нь өнөө л цаг хүндрэх үед хөлд нь сөгддөг ОУВС. Хямралаас гарахын тулд Монгол Улс ОУВС дахин хандах уу, хандахгүй гэвэл дампуурлаа шууд олон улсад зарлах уу. Шинээр бүрдэх Засгийн газарт сонголт тун хомс байна. Сонголт хийх боломжоо эрх баригчид өөрсдөө үгүйсгэсэн. Хамгийн хал багатай нь магадгүй ОУВС-д хадаг барих л болов уу.

Өмнөх 2017 онд тус сангаас авсан "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" үр дүн тааруу хэрэгжсэн болохоор өнөөдүүл нь манайхыг тоохгүй байхыг үгүйсгэх аргагүй. Хүний итгэлийг бид өөрсдөө алдсан улс. Тийм болохоор өгөхгүй гээд нэг гэдийвэл ирэх дөрвөн жилийн эрх баригчдын мөрийн хөтөлбөрийн биелэлтийн талаар саналтгүй. Нөхцөл байдал өнөөгийнхөөс илүү хүндэрнэ гэсэн үг.

Хэрэв ОУВС-тай нааштай хэлэлцээрт хүрвэл Монгол Улс найм дахь удаагаа санхүүгийн дэмжлэг хүссэн тусгай хөтөлбөрт хамрагдана гэсэн үг. Дордохын долоо гэж энэ. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" манай улсад хэрэгжүүлсэн ОУВС-гийн зургаа дахь хөтөлбөр. Үүнээс өмнө 2009 онд Stand-by, 2001 онд Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрт хамрагдаж байсан удаатай. Мөн энэ онд тус сангийн "Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр"-т хамрагдсан. Зах зээлийн эдийн засагт шилжсэн сүүлийн 30 жилд долоон удаа ОУВС-д манай улс хандсан бөгөөд 90-ээд оны үед хамгийн ойрхон давтамжтай хандаж байв.

Харин 2000 он гарснаас хойш 8-9 жилийн завсартай ОУВС-д хандсан. **Харин сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хоёр удаа буюу хамгийн их ойрхон давтамжтай ханджээ. Өөрөөр хэлбэл, сонгуульт дөрвөн жилийн хугацаанд Засгийн газар хоёр удаа хандсан нь санхүүгийн сахилга бат, засаглалын чанар, бүтээмж хэр байсныг илтгэнэ.** Тусгай хөтөлбөрт дахин хамрагдвал төсөв, мөнгөний бодлогыг У.Хүрэлсүхийн Засгийн газар, төв банк бус ОУВС тодорхойлно. ■

ЗГМ: ИНФОГРАФИК

ӨРИЙН СТАТИСТИК 2020 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД
(Засгийн газрын нийт өр, тэрбум төгрөг)

2019.I-III		2020.I-III
22 350.4		24 552.1
1533.5	Дотоод өр	1359.4
18 927.9	Гадаад өр	21180.1
804.4	Концесс	957.1
1084.6	Засгийн газрын өрийн баталгаа	1055.5

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР
(сая ам.доллар)

2019.I-III	2020.I-III
29 521.8	30 461.1

Эх сурвалж: ҮСХ

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 сарын 30

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хувьсгалчдын гудамжнаас Хонхорын 6-177б хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 11 дүгээр хороо/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ/202002417

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хувьсгалчдын гудамжнаас Хонхорын 6-177б хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 11 дүгээр хороо НХААГ/202002417 тоот ажлыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтнаас үнэгүй татаж авч болох бөгөөд тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер ирүүлэхдээ цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр тендерт оролцох хураамж 50,000 (тавин мянга)-н төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт **16 000 000** /Арван зургаан сая төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн, 09 цаг 10 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар хороо, Агар-4 гудамж Г-31 байр, 102 тоот Худалдан авах ажиллагааны алба, Утас: 7000-0717, 7000771
Веб сайт: www.tender.gov.mn
Имэйл хаяг: songinohairhan@procurement.gov.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 сарын 30

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тендер шалгаруулалтын нэр: 10 дугаар хорооноос Баянхошууны шинээр баригдаж буй цэцэрлэг хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 10 дугаар хороо/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ/202002420

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос 10 дугаар хорооноос Баянхошууны шинээр баригдаж буй цэцэрлэг хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 10 дугаар хороо/ НХААГ/202002420 тоот түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ажлыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтнаас үнэгүй татаж авч болох бөгөөд тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер ирүүлэхдээ цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр тендерт оролцох хураамж 50,000 (тавин мянга)-н төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт **15 000 000** /Арван таван сая/ төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн, 09 цаг 15 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.
Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар хороо, Агар-4 гудамж Г-31 байр, 102 тоот Худалдан авах ажиллагааны алба, Утас: 7000-0717, 7000771
Веб сайт: www.tender.gov.mn
Имэйл хаяг: songinohairhan@procurement.gov.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 сарын 30

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Батсүмбэр орох замаас төвийн хэсэг, арын худаг хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 21 дүгээр хороо/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ/202002419

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Батсүмбэр орох замаас төвийн хэсэг, арын худаг хүртэлх хатуу хучилттай авто зам /СХД, 21 дүгээр хороо/ НХААГ/202002419 тоот
ажлыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтнаас үнэгүй татаж авч болох бөгөөд тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер ирүүлэхдээ цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр тендерт оролцох хураамж 50,000 (тавин мянга)-н төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт **28 000 000** /Хорин найман сая/ төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн, 09 цаг 25 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар хороо, Агар-4 гудамж Г-31 байр, 102 тоот Худалдан авах ажиллагааны алба, Утас: 7000-0717, 7000771
Веб сайт: www.tender.gov.mn
Имэйл хаяг: songinohairhan@procurement.gov.mn

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 сарын 30

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянхошууны авто замаас зүүн тийш 264 дүгээр цэцэрлэгийн урдуур Баянхошууны эцсийн буудал хүртэлх туслах замтай холбох хатуу хучилттай авто зам /СХД, 28 дугаар хороо/

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ/202002418

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянхошууны авто замаас зүүн тийш 264 дүгээр цэцэрлэгийн урдуур Баянхошууны эцсийн буудал хүртэлх туслах замтай холбох хатуу хучилттай авто зам / СХД, 28 дугаар хороо/ НХААГ/202002418 тоот ажлыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтнаас үнэгүй татаж авч болох бөгөөд тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендер ирүүлэхдээ цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр тендерт оролцох хураамж 50,000 (тавин мянга)-н төгрөгийг www.tender.gov.mn -ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт **28 000 000** /Хорин найман сая/ төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 сарын 30-ны өдрийн, 09 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар хороо, Агар-4 гудамж Г-31 байр, 102 тоот Худалдан авах ажиллагааны алба, Утас: 7000-0717, 7000771
Веб сайт: www.tender.gov.mn
Имэйл хаяг: songinohairhan@procurement.gov.mn

ДЭЛХИЙ

Энэтхэгийн сая сая ажилчин дүрвэж байна

Нүүдлийн ажилчдад хот руу буцах шалтгаан байхгүй

Хөл хорионы үед Дели хотоос автобусаар гарч буй нүүдлийн ажилчид. 2020 оны гуравдугаар сар.

Шрути Шривастава

3-5 дугаар сарын хооронд Энэтхэгийн мега хотуудаас 10 сая орчим хүн гадагш дүрвэжээ.

Дэлхийн хамгийн аварга цар хүрээтэй хөл хорионы улмаас ажлаасаа хагацсан хүмүүс өлөн зэлмүүн, ар гэрээсээ алс хол амьдарч байна. Ази тивийн гурав дахь гол эдийн засаг өдгөө хөл хориогоо аажим зөөлрүүлсээр байгаа ч ажиллах хүчний томоохон хэмжээний нүүдлийн сөрөг нөлөө хаа сайгүй илэрсээр. Том хотууд ажиллах хүчний дутагдлаа нөхөж дийлэхээ байлаа. Хөдөөгийн муж улсууд дахь ядуу зүдүү айл өрхийн амьдрал хотоос ирдэг мөнгөний урсгал зогссоноор хуучнаасаа дордох шинжтэй болсон нь төрийн санд хүнд ачаа болох төлөвтэй.

Коронавирус тархсаар байгаа тул ажлын байр сэргэх нь одоо ч тодорхой бус, нүүдлийн ажилчид хотуудад буцах бодолгүй. Муж улсууд төрөл бүрийн төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлсээр байгаа ч Энэтхэгийн эдийн засаг сүүлийн 40 жилд анх удаа муудлаа. Цаашид ажлын байр сэргэхгүй нөхцөлд улс төрийн эмзэг уур амьсгал улам хурцадна.

Цар тахлын нөхцөл нь "ялангуяа доод кастын гаралтай, нэн эмзэг, ядуу зүдүү, нүүдэллэгч ажилчдын ар гэрийнхэнд эдийн засгийн том цохилт болно" хэмээн Мумбайд төвтэй судалгааны India Migration Now группийг үндэслэгч Варун Агарвал анхааруулж байна.

Энэтхэгт хөл хорио тогтоосон эхний 15 хоногт дотоодын мөнгөн гуйвуулгын хэмжээ 90 хувиар унасныг тус улсын төлбөрийн томоохон банкийг эрхлэн хөтөлдөг, Мумбайд төвтэй Fino Paytach Ltd компанийн гүйцэтгэх захирал Риши Гупта тайлбарлав.

Дараа нь тавдугаар сарын эцэс гэхэд нэг удаагийн гуйвуулгын дундаж хэмжээ 1750 рупи (23 ам.доллар) хүрч сэргэсэн нь цар тахлаас өмнөх үеийн дунджийн тал орчим хувь болж байна. Байдал хэзээ бүрэн сэргэхийг Гупта хэлж мэдэхгүй. "Нүүдлийн ажилчдад хот руу буцахаар яарах шалтгаан байхгүй. Зарим нь огт буцахгүй ч байж мэднэ" хэмээн захирал өгүүлсэн юм.

Ажилчид буцалгүй төрөлх муж улсдаа үлдэцгээх аваас бодлого тодорхойлогчдод мөнгөн гуйвуулгаас ч ноцтой шинэ бэрхшээл үүснэ. Хэрэглээ буурч, муж улсуудад ажиллах хүчний илүүдэл үүсэх нь цалин буурахад хүргэж "улмаар орон нутгийн эдийн засагт шок болно" хэмээн тэр бээр анхааруулав.

Энэтхэг нь эдийн засагтаа түлхэц өгөх 277 тэрбум ам.долларын багцыг тавдугаар сард зарласны зэрэгцээ хөдөөгийн ажилчдад ажлын байр үүсгэхэд зориулан долоон тэрбум ам.долларын хөтөлбөр санаачлаад байна. ■

Цар тахал хүнсний хэрэглээг өөрчиллөө

Эндрю Блэкмэн

Франкфуртер зайдсыг бүтээсэн улсад махны дуршил буурсны зэрэгцээ мах боловсруулах арга хэлбэр ч өөрчлөгдөж эхэллээ.

COVID-19 цар тахлын улмаас ресторан, хоолны газрууд гуравдугаар сард хаагдахаас бүр өмнө олон герман хэрэглэгч хэдийн мах идэхээ багасгажээ. Улс орныг хамарсан хөл хорио өдгөө зогссон ч хүнс боловсруулах салбар, ялангуяа нядалгааны газруудыг коронавирус хямраасан хэвээрээ.

Гютерсло хотын ойролцоох мах боловсруулах үйлдвэрийн 2,000 гаруй ажилчинд вирус халдварласан тул эрх баригчид энэ долоо хоногийн эхээр тус бүс нутагт хөл хориог сэргээлээ. Мах боловсруулах үйлдвэрийг эзэмшигч Toennis GmbH дэд гэрээлэгч ашиглахаа зогсоох зэргээр үйл ажиллагаандаа зохих өөрчлөлт оруулав.

Засгийн газар ч ХБНГУ даяар үндсэндээ 200 мянга орчим цагаач ажилчдад тулгуурлан ажилладаг мах боловсруулах үйлдвэрүүдийг хаахаар төлөвлөж байна.

ХБНГУ даяар үндсэндээ 200 мянга орчим цагаач ажилчдад тулгуурлан ажилладаг мах боловсруулах үйлдвэрүүдийг хаахаар төлөвлөж байна.

Боловсруулах үйлдвэрийн ажилчдыг олон цагаар ажиллуулж, бага цалин олгох нь нийтлэг. Хөдөлмөрийн яамны судалгаанаас үзвэл боловсруулах үйлдвэрүүдэд халдвараас сэргийлж аюулгүй зай барьж ажиллах нөхцөл муу, хувийн хамгаалалтын хэрэгсэл хомс. Дээр нь ажилчдын орон сууцны орчин нөхцөл хэт шахуу, эрүүл ахуйн шаардлагад тэр бүр нийцдэггүй.

Дэлхий даяар мах боловсруулах үйлдвэрүүд коронавирусийн голомт болж хувирсаар. АНУ-д байдал бүр ноцтой, олон мянган ажилчин тестээр эерэг гарч үйлдвэрүүд хаагдсаны улмаас жижиглэн худалдаа, түргэн хоолны сүлжээнүүдэд махны түр хомсдол үүсэв.

ХБНГУ-д энэ бэрхшээл эрэлттэй илүү холбогдож байна. Тус улсад цагаан хоолтны бургер гэх мэт махны орцгүй хүнсний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байгаа өнөөгийн нөхцөлд мах боловсруулах үйлдвэрүүдийн зардал өсөхөөс аргагүй. Цаашдаа хэрэглэгчид жинхэнэ махан франкфуртерт ахиу үнэ төлж эхлэх цаг бүрхэг хэвээр. ■

Сингапурын сөрөг хүчин амьдралын өндөр өртгийг эсэргүүцэв

Сингапурын улс төрийн гол сөрөг нам амьдралын өндөр өртөг зардлыг багасгах, иргэдийн амьдралын баталгааг хангахад чиглэсэн сонгуулийн тунхаг дэвшүүллээ.

Тус улсын Ажилчны намаас (Worker's Party) ням гарагт нийтэлсэн сонгуулийн өмнөх тунхаг нь бараа, үйлчилгээний татварыг өсгөх засгийн газрын төлөвлөгөөг эсэргүүцэж, цалингийн үнэмлэхүй доод хэмжээ, ажилгүйдлийн даатгалыг дахин баталгаажуулахад чиглэсэн утгатай байгаа юм. Тус нам бүтэн цагаар ажиллагсдын гар дээрээ авах сарын цалингийн үнэмлэхүй доод хэмжээг 1,300 сингапур доллар (934 ам.доллар) хүргэх арга эрэлхийлж байна.

"Үндсэн тэжээгч чадлаараа зүтгээд ч олон сингапур айл сараас сарын хооронд цалин дөнгөн данган хүрч байгаа"-г тунхагт тайлбарлажээ. **Цаашид тэтгэврийн нас заах явдлыг зогсоож, сингапур иргэн чадлынхаа хэрээр урт ажиллах нөхцөл бүрдүүлэн, цомхотголоор халагдсан хүмүүсийн санхүүгийн дарамтыг хөнгөвчлөх даатгалын хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн тус нам үзлээ.**

Цар тахлын үед цалин, орлогын татварыг түр зогсоож иргэд, бизнесийн байгууллагуудад туслах үүднээс Сингапурын засгийн газар ирэх гурван сард эдийн засагт түлхэц өгөх нийт 92.9 тэрбум ам.долларын дөрвөн багц зарлаад байна. ■

НЭРИЙН ХУУДАС ХЭРЭГЛЭХ СОЁЛ

Ажил хэргийн харилцаа нэрийн хуудас солилцохоос эхэлдэг

Н.Сийлэн, ЗГМ сонин

Нэрийн хуудас нь ажил хэрэгч харилцааны хамгийн чухал хэсэг бөгөөд амжилтын эхлэл гэж үзэж болно. Та бизнес уулзалтын үеэр ганц л буруу алхам хийхэд таны мэргэжлийн имижийг бүхэлд нь хохироох эрсдэлтэй. Бусдад гайхалтай сэтгэгдэл төрүүлэхийн тулд уран яруу, өндөр итгэл үнэмшилтэй ярьж, сайхан хувцаслахаас гадна ёс суртахууны хувьд өөгүй байх ёстой. Тиймээс энэ удаагийн "Хувь хүний хөгжил" буланд нэрийн хуудас солилцох, ашиглах соёлын тухай мэдээлэл бэлтгэлээ.

СОНГУУЛЬТ АЖИЛ ХАШДАГ БОЛ НЭРИЙН ХУУДАСНУУДАА ТУС ТУСАД НЬ ХИЙЛГЭ

Нэрийн хуудас нь ажил хэргийн, хувийн болон гэр бүлийн гэсэн гурван төрөлтэй. Гэр бүлийн нэрийн хуудаст овог нэр, ургийн овог, имэйл хаягаа бичдэг бөгөөд гэр бүлийн найз нөхөд болох, баяр хүргэх, баяр ёслолоор бэлэг сэлт хүргүүлэхдээ хамт илгээх зорилгоор авч явдаг. Харин ажлын нэрийн хуудсанд дээрх мэдээллүүдээс гадна тухайн хүний цол хэргэм, шуудангийн болон интернэт хаяг, утас, факсын дугаарыг бичдэг. Мөн зарим оронд байгууллагын нэрийн өмнө үйл ажиллагааны чиглэлийг заавал бичдэг ёстой. Хэрэв та үндсэн ажлаасаа гадна хэд хэдэн сонгуульт ажил эрхэлдэг бол нэрийн хуудсаа тусад нь хийлгэх нь зүйтэй.

АЖЛЫН НЭРИЙН ХУУДСАА БАЙНГА АВЧ ЯВ



Танд ажил хэргийн гайхалтай боломжууд ямар ч үед үүсэж болох бөгөөд хэн нэгэнтэй шинээр харилцаа холбоо тогтоох үед нэрийн хуудсаа мартсан байвал боломжоо алдаж ч магадгүй. Тиймээс ямагт бэлэн байж нэрийн хуудсаа биедээ авч яв. Утасны дугаараа цаасан дээр тэмдэглэхийн оронд нэрийн хуудсаа өгөх нь таныг ажил хэрэгч хүн болохыг илтгэнэ.

НЭРИЙН ХУУДАС ШРИФТЭЭС ЭХЭЛДЭГ

Нэрийн хуудаст тогтсон стандарт гэж бий бөгөөд хамгийн чухал зүйл нь шрифт юм. Таны нэрийн хуудсан дээр бичсэн бичвэр уншихад хялбар байх ёстой ба хэт тод биш, хагас бүдүүн үсгээр бичигдвэл зохистой. Түүнчлэн нэрийн хуудсанд ямар нэг хүрээ, хашлага хэ хийх шаардлагагүй бөгөөд хамгийн түгээмэл цагаан өнгийг сонгоорой. Харин хэмжээний хувьд 7х4 см хэмжээтэй нэрийн хуудас нь авч явах нь тохиромжтойд тооцогдоно. Мөн эрэгтэй хүний нэрийн хуудас 5х9 см, эмэгтэй хүнийх 4х9 см, төр, засгийн дээд албан тушаалтнуудын нэрийн хуудас 6х10 см хүртэл хэмжээтэй байж болдог. Олон улсын хэмжээнд хэвшсэн ёсоор нэрийн хуудасны зөвхөн нэг тал нь л бичигтэй байна. Иймд хоёр өөр орны хэлээр бичсэн нэрийн хуудастай байх хэрэгтэй.

НЭРИЙН ХУУДСАА ҮНЭ ЦЭНТЭЙ БАЙЛГА



Бизнес уулзалт, олон хүнийг хамарсан арга хэмжээний үеэр нэрийн хуудсаа чихэр санал болгож байгаа мэт тараах хэрэггүй. Ялангуяа өөр хүнтэй ярилцаж буй хүний гарт нэрийн хуудсаа атгуулах нь хамгийн бүдүүлэг үйлдэл юм. Энэ нь та үнэ цэнтэй байж, өөрийн ажил хэргийн нэр хүндээ хадгалахад чухал ач холбогдолтой.

ХАРИЛЦАЖ БУЙ ХҮНЭЭ АЛБАН ТУШААЛААР НЬ ХҮНДЭТГЭЖ ДУУДНА



Нэрийн хуудас бол танилцах, холбоо тогтоох чухал алхам. Тиймээс мэндэлснийхээ дараа нэрийн хуудсаа өгөх ёстой. Хэрэв та харилцаж буй хүнийхээ нэрийн хуудсыг нь авсан бол зөвхөн нэрээр нь эсвэл цол хэргэм, албан тушаалаар нь "Ноён Бат, Эрхэм захирал аа" гэх зэргээр дуудах нь зөв. Нэрийн хуудсаа өгөхдөө овог нэрээ чанга, тод хэлж харилцаж буй хүн рүүгээ зөв харуулан хоёр гараараа өгөх бөгөөд үл ялиг бөхийх нь хүндлэлийг илэрхийлнэ. Нэрийн хуудсыг авахдаа мөн хоёр гараараа хүндэтгэн аваад шууд унших ёстой. Хэрэв уншилгүй халаасандаа хийвэл нөгөө хүнээ хүндэтгэхгүй байгааг илэрхийлнэ. Хэрэв нэг гараараа авах бол баруун гараараа аваарай. Бөхийх болон хоёр гараараа өгөх дүрэм Азийн орнуудад хамгийн чухал. Мөн танилцах үед насаар бага хүн юм уу эрэгтэй нь нэрийн хуудсаа түрүүлж өгдөг. Харин ажил хэргийн уулзалтын үед хүлээн авч буй тал эхэлж өгөх ёстой.

Энэ зуны нарны шилний трэндүүд

Энэ жилийн нарны шилний загварыг бүхэлд нь этгээд гэх ганц үгээр тодорхойлж болно



ТЭГШ ХЭМ

Нарийхан, тэгш өнцөгт хэлбэр бүхий энэ шил 90-ээд оны улаан хивсний ёслолоос буцан ирж байна. Супер моделиудын хамгийн hot сонголт таныг ч халуухан харагдуулна.

Н.Сийлэн, ЗГМ сонин

Аагим халуун зуныг аялал зугаалгагүйгээр төсөөлшгүй. Харин аялал зугаалгыг нарны шилгүйгээр төсөөлшгүй. Энэ зуныг өнгөлөх нарны шилний трэндийг Vogue, Whowhatwear зэрэг загварын сэтгүүлээс онцолж байна.

АВИАТОР

Авиатор загвар хэзээ ч хуучрахгүй бас дизайнеруудын сонголтоос арчигдахгүй. Энэ жил ч мөн адил. Нүүрний дийлэнх хэсгийг буюу бүхэлд нь хаахуйц өвөрмөц шил сонгож өөрийгөө нисгэгч мэт мэдрээрэй.





МУУРЫН НҮД

Бас нэгэн ретро хэв маягийн төлөөлөл, хамгийн сонгодог нарны шил бол муур хэлбэртэй шил. Та энэ шилийг сонгосноор илүү донжтой, загварлаг харагдах болно.

ТУНГАЛАГ ӨНГӨ

Тунгалаг хүрээ, линз өнгөрсөн зунаас хойш нарны шилний зах зээлд хүч түрэх болсон. Энэ чиг хандлага байр суурьа хадгалж үлджээ. Тод өнгийн линзтэй нарны шил таны харцыг тодотгож, зуны цоглог, хэв маягийг бүрдүүлнэ.



ГИНЖ

Гинж 2020 оны загварын салбарыг бүхэлд нь ноёрхож буй. Гутал, хувцас, үнэт эдлэл гэхгүй бүх л зүйлийг гинжээр тодотгох болжээ. Таныг өвөрмөц, этгээд, загварлаг харагдуулна.



РАМНЫ ЧИМЭГЛЭЛ

2020 оны нүдний шилний чиг хандлагад хэт их гоёл чимэглэл ороогүй боловч рамыг нь чимэглэсэн загвар өнгө нэмж байна. Даруухан өнгө сонгож, тансаг шилээрээ өөрийгөө тодотго.



ХАЧИРХАЛТАЙ ХЭЛБЭР

Өнцөгтэй хүрээ, хурц шийдэл, хачирхалтай хэлбэр бүхий шилнүүд ч зуны трендэд багтана. Энэ төрлийн шилнүүд танд ер бусын мэдрэмж төрүүлнэ гэж мэргэжилтнүүд амлаж байна.

Д.Баярхүү, судлаач проф.

ГУРАВДАГЧ ХӨРШ МОНГОЛД ХУУЛЬЧЛАГДСАН

Стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална гэж зориуд онцлон заасан

Гуравдагч хөрш хэнд ч хэрэггүй, Америк юугаар гийгүүлсэн юм, аль вэ тэр баруун чинь, хоёр хөршөөсөө хаашаа ч зайлахгүй гэх үзэл бодолтой, түүндээ бүр фанат болчихсон нөхөд УИХ-д олон өрсөлдөө. Засгийн эрх барилцах хувьгүй, барилцаагүйгээ ч гадаад бодлого руу нулимж гутааж илэрхийлдгийг нь уучлаад дараах өгүүлэлд анхаарлыг нь хандуулъя.

Монгол Улсын газар зүйн ба геополитикийн гарцаагүй бодит тулгалт, түүхэн эрхшээл бол хил залгаа хоёрхон хөрштэй байж ирсэн явдал мөн. Монгол Улсын оршин байх, хөгжин дэвжих, уруудан доройтох, тэсч үлдэх, эргэж сэргэх бүх түүхэн процесс чинь энэ хоёр хөрштэйгээ хэр харилцаж ирэв гэдгээс ихээхэн шалтгаалж ирсэн.

Хоёр хөршөөсөө гадна гуравдагч хөрштэй болох нь чухал (бүр ч чухал) гэдгийг 1990-ээд оны эхэн үеийн Монголын төр засаг, улс төрийн намууд зөвөөр олж харж, байр сууриа зөвөөр томъёолсон ба Ж.Бейкер, Т.Кайфу нарын айлчлал түүхэн сэдлийг өгсөн. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жэймс Бейкер Монголд айлчлахдаа "Танайх хоёр хөрштэй орон. Америк танай гуравдагч хөрш байж яагаад болдоггүй юм бэ" гэсэн утгатай үг хэлжээ. Хамгийн нөлөө бүхий орны дипломатч хэлсэн учир судлаачид ч гуравдагч хөршийн бодлогын судалгаанд мордсон, одоо ч судалсаар байна, тэдний нэг нь энд бичиж байна.

Монгол дахь Орос, Хятадын ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, нөгөө талаас гуравдагч хөрш гэх АНУ, Япон, Энэтхэг, Өрнөд Европын Монгол дахь ашиг сонирхлыг бололцооны хэлбэрээр түлхүү оруулж ирэх, ахиулах нь манай гадаад бодлогын торгон чиг шугам гэдгийг 1990-ээд оны эхнээс л бид ойлгож мэдэрч, ухаанаа уралдуулж, хэрэгжүүлж иржээ. **Монгол Улсын тусгаар тогтнолын нэг баталгаа хэмээн үзэх явдал ч түгээмэл буй. Тэр тухайгаа бүр хуульчлаад тунхаглачихсныг энд эх сурвалжтай нь тавья.**

Монгол Улсын гадаад бодлогыг анх удаа 1994 онд "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Гадаад бодлогын үзэл баримтлал"-аар хуульчлан тунхагласан. Гадаад бодлогын үзэл баримтлалыг мөрдөж ажилласан 15 жилийн туршлагадаа тулгуурлан дахин боловсруулалт хийж 2011 оны хоёрдугаар сарын 10-нд шинэчлэн батлагдсан. Түүнд гуравдагч хөршийн тухай анх удаа нэн тодорхой зааж өгчээ.

II бүлэг–Улс төрийн гадаад харилцааны бодлого гэх хэсгийн 14 дүгээр заалт болох "Монгол Улс улс төрийн гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхдээ дараахи чиглэлийг баримтална" гэсэн нь улс бүр дээр нэр зааж хэрхэн харилцахаа томъёолсон бэлэн жор гэхээр туссан юм. Үүнд 14.2.АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх гэсэн бүр заагаад өгчихжээ.

Үзэл баримтлалын III бүлэг– Эдийн засгийн гадаад харилцааны бодлого гэх хэсгийн 21 дүгээр заалт "Эдийн засгийн гадаад харилцааны бодлогыг дараахи чиглэлээр хэрэгжүүлнэ" гэдэгт "гуравдагч хөрш"-ийн гэж зааж өгөөгүй ч тэдий оролцоотой явуулах бодлого үйл ажиллагааг томъёолжээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй нэмэгдүүлэх гэсэн заалт бол "гуравдагч хөрш"-ийн хөрөнгө оруулалтаар тэнцвэрийг ханга гэж шууд бууж байна.

Үзэл баримтлалын IV бүлэг– Шинжлэх ухаан-технологийн гадаад харилцааны бодлого гэх хэсгийн олон заалтат зорилтууд нь "гуравдагч хөршүүд"-ийн ШУТ-ийн ололт дэвшлийн оролцоогүйгээр хэрэгжих нөхцөлгүй гэдгийн үндэслэл, энэ чиглэлээр тэдгээр улсын хөрөнгө оруулалт, тусламжийг эх орондоо татах чухал эрх зүйн үндэс болно.

Үзэл баримтлалын VII бүлэг– Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэх хэсэгт "гуравдагч хөршүүд"-тэй хамтран ажиллахыг шууд зааж өгсөн гэж үзэж болно. Үүнд Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино гэжээ. **"Ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах" гэсэн нь ардчилсан бус хоёр хөршийг давж харилцана, тэр сурталчилгааг хоёр хөршид таашаахгүй, тиймээс өөр түнш эрэлхийлнэ, тэгж баймааж нь эерэг ойлголт буй болгоно, талархан дэмжигчдийг өргөтгөнө гэсэн үг юм.**

Бүхэлд нь авч үзвэл Гадаад бодлогын үзэл баримтлалд хоёр хөрштэйгээ муудалцахгүйгээр гуравдагч хөршүүдтэй харилцах, тэднийг өвөр хооронд нь мөргөлдүүлэхгүйгээр ухаалгаар, энх тайванч хамтын ажиллагаа өрнүүлнэ хэмээн тов тодорхой зааж суулгаж өгсөн хэмээн дүгнэж болно.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг мөрдөж ажилласан 15 жилийн туршлагадаа тулгуурлан дахин боловсруулалт хийж 2010 оны долдугаар сарын 15-нд шинэчлэн батлагдсан. Гуравдагч хөрш гэдэг нь хөгжил дэвшлийн баталгаа, олон улсын харилцаанд эрх тэгш оролцохын баталгаа хэмээн өмнөх үзэл баримтлалд олон талаас нь томъёолж өгсөн бол энэхүү үзэл баримтлалд тийм хамтын ажиллагаа нь аюулгүй байдлын баталгаа болно хэмээн үзсэн.

3.1.1.5-д "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ гэсэн нь ардчилсан бус дэглэмтэй хоёр хөрш биш гэдгийг шууд хэлж өгсөн, мөн гуравдагч хөрш хэмээн хэргээр зааж оруулан, өрнө-дорнын өндөр хөгжилтэй улсуудаа зориуд битүү нэрлэсэн хэрэг юм.

> **ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД ХОЁР ХӨРШТЭЙГЭЭ МУУДАЛЦАХГҮЙГЭЭР ГУРАВДАГЧ ХӨРШҮҮДТЭЙ ХАРИЛЦАХ, ТЭДНИЙГ ӨВӨР ХООРОНД НЬ МӨРГӨЛДҮҮЛЭХГҮЙГЭЭР УХААЛГААР, ЭНХ ТАЙВАНЧ ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛНЭ ХЭМЭЭН ТОВ ТОДОРХОЙ ЗААЖ СУУЛГАЖ ӨГСӨН ХЭМЭЭН ДҮГНЭЖ БОЛНО.**

3.1.1.6-д Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно гэж заасан нь эдүгээгийн манай батлан хамгаалахын гадаад харилцааны эрх зүйн үндэс болоод хэрэгжиж байна. **Батлан хамгаалахын салбарт улсынхаа гадаад харилцаанаас дутахгүй олон талт, хоёр талт хамтын ажиллагаа өрнүүлээд байгаа нь Үзэл баримтлалын энэ заалт хамгийн бодитой хэрэгжиж байгаагийн үлгэр жишээ хэмээн үзэж болно.**

3.1.1.8-д Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно гэжээ. Энэ заалт гуравдагч хөршүүдийн оролцоогүй хэрэгжихгүй нь ойлгомжтой. Аюулгүйн Зөвлөлийн гишүүд, Зүүн ба Зүүн хойд Азийн бүс нутагт манай гуравдагч хөрш хэмээн нэр төртэй нэрлүүлж буй улсуудыг энд нэр заагаагүй ч цаагуурааа хэлжээ. Энэ баримт бичгээс "Эдийн засгийн аюулгүй байдал" гэсэн дэд бүлгийг жичид нь авч үзэх хэрэгтэй. Учир нь "олон тулгуурт бүтэц" гэж тусгайлан зааж өгсөн. Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ гэжээ бүр шууд зааж өгснөөрөө **олон тулгуурт эдийн засгийн бодлогын цаад зорилго нь Монгол Улс Европын орнуудын хөгжлийн загварыг сонгоно, дэмжлэг туслалцаа тэндээс авна гэсэн хэтийн зорилтоо биелүүлэн хэлж өгсөн болов уу хэмээн үзэж байна.**

Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого гэх дараагийн дэд бүлгээс гуравдагч хөршийн бодлогын зарим нэг нарийвчлалыг эрэлхийлж болох юм. Стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална гэсэн нь хөрөнгө оруулалтад хоёр хөрш давамгайлахгүй, гуравдагч хөршүүд ч чөлөөтэй орж болно, гэхдээ аль алиных нь тэнцвэрийг хангана гэсэн үг юм.

Гуравдагч хөрштэй болох байх тухай эрх зүйн баримт бичгүүдийг ийнхүү хангалттай боловсруулж албажиж, хэрэгжих шатандаа яваа. Гол үр дүн юу байв гэсэн асуулт эдүгээ ч бүрэн хариултаа олоогүй байгаа. Маргаан мэтгэлцээн явсаар байна.

Гуравдагч хөршийн бодлого хоёр хөршид таалагдахгүй, тэр дундаа ОХУ-тай улс төрийн итгэлцэл хөгжүүлэхэд садаа болж байгаа мэтээр ярих хэлэх, хардах явдал манай зарим судлаачид, ахмад дипломатчдын дунд мэр сэр ажиглагддаг учраас би УИХ-ын шинэ гишүүдэд санаа сэдэл өгөхөөр зориуд энд ийнхүү буулгалаа. Хоёр хөршийг хэт шүтэгсэд улстөрчдөд элдэв мэдээлэл өгч, төрийн гадаад бодлогыг будлиулах явдал 2017-2018 онд харагдсан. Оросгүйгээр хаашаа ч явахгүй, яаж ч хөгжихгүй, Оросын Монгол дахь ашиг сонирхлыг монголчууд туйлшраад хөөгөөд гаргачихсан, тэр харилцааг эргэж сэргээх нь нэн чухал, түүний нотолгоо болгож ШХАБ-д жинхлэх нь зөв хэмээн ярьсан явдал буй билээ. ■

Коронавирусийг хагас минутын дотор устгах арга нээжээ

У.Насан, ЗГМ Сонин

Бостоны их сургуулийн дэргэдэх халдварт өвчлөлийн лабораторийн судлаачид коронавирусийг зайнаас тусгасан хэт ягаан туяагаар бүрэн устгаж болохыг илрүүллээ гэж Biospace сайт мэдээлжээ. Микробиологич Энтони Гриффитс тэргүүтэй эрдэмтдийн баг SARS-CoV-2 вирусээр бохирдсон материалд хэт ягаан туяаны янз бүрийн дозыг тусгаж, тухай бүрд нь вирусийг устгах хурдыг хэмжсэн байна. Жишээ нь, **5 мж/см2 дозтой туяагаар зургаан секунд шарахад вирусийн тархалт 99 хувь буурсан байна.**

Эрдэмтдийн үнэлснээр 13 ваттын чадалтай эрчим хүч хэмнэдэг чийдэн 15 шоо метр талбайтай өрөөг коронавирусийн хэсгүүдээс цэвэрлэх чадвартай аж. Тэдний ярьснаар хэт ягаан туяаг бактерийн эсрэг хэрэгсэл болгон 40 жил ашиглаж байгаа бөгөөд энэ хугацаанд туршилтад орсон ямар ч вирус тэсэж үлдээгүйг тэмдэглэв. Гэхдээ хэт ягаан туяа өөрөө хүнд аюултай. Судлаачдын багийн ахлагч туршилтын үр дүн болон аргачлалын тайлангаа аль нэг сэтгүүлд нийтлүүлэхээ амлав. ■

Японд өвчлөх магадлалыг урьдчилан оношилж чаддаг боллоо



Японы эрдэмтдийн баг 20 орчим өвчлөл гурван жилийн хугацаанд хэрхэн үргэлжлэх үйл явцыг тооцоолох арга боловсруулжээ. Киодо агентлагийн мэдээлснээр Киото дахь Хиросаки их сургуулийн судлаачид хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүний биеийн хорь орчим үзүүлэлтээр эрүүл мэндийн анализ оношилгоо хийх арга зохиосон байна. Үүнд, ерөнхий биеийн байдал, генетикийн онцлог, амьдралын хэв маяг болон хорт зуршлуудыг багтаав.

Тухайлбал, чихрийн шижин, оюуны доройтол зэргээс гадна уг систем цусны даралт, бөөрний дутагдал, өөхлөлт, зүрхний шигдээс гэх мэт хэд хэдэн өвчин үүсэх магадлалыг урьдчилан таамаглаж чадна. Уг аргыг 20 мянга орчим хүний өгөгдөлд суурилан боловсруулжээ. **Киотогийн их сургуулийн профессор Ясуси Окуно "Бид ирэх гурван жилд хүнд ямар өвчин тохиолдож болохыг өндөр нарийвчлалтайгаар урьдчилан хэлж чадсан" хэмээв.** Эрдэмтдийн ярьснаар уг аргыг ашиглан эртнээс ямар нэг алхам хийх буюу амьдралын хэв маягийг өөрчлөх замаар зарим өвчнөөс зайлсхийж болох юм. ■

Хорт хавдрын хэмжээг 70 хувь багасгадаг эм бүтээв

Британийн Үндэсний эрүүл мэндийн системийн эрдэмтэд хорт хавдар эмчилгээгүй үе шатандаа орсон ч туслах чадвартай эм бүтээснийг Daily Mail сонинд мэдээлжээ. Эргэлт гаргасан энэхүү эм эмнэл зүйн сорилтыг давж, зургаан төрлийн хорт хавдартай тэмцэхэд үр дүнтэй гэж хүлээн зөвшөөрөгдсөн байна. Шинэ эм том хэмжээний хорт хавдрын бөөгнөрөлд нөлөөлж, хэмжээг нь 70 хувиар багасгах чадвартай гэж тооцжээ. **Хүний бие дэх хавдрын байрлалаас үл хамааран эмнэж чадах уг эмийг Entrectinib хэмээн нэрлэсэн аж.**

Үндэсний ЭМС-ийн судлаач Мейндерт Бойсен "Entrectinib-ийн эмчилгээний арга хорт хавдрын эмчилгээнд хувьсгал гаргах боломжтой. Байрлалаас үл хамааран хавдрыг томруулдаг генетикийн мутацыг зогсооход чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг" хэмээн тайлбарлав. Хорт хавдрыг эмчилдэг уламжлалт аргууд нь хавдрын байрлалаас ихээхэн хамаардаг. Уг эмийг 12-оос дээш насны хавдрын ховор төрлөөр өвчилсөн хүмүүст зориулсныг судлаачид онцлов. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Багц №1: Сургуулийн гал тогооны тохижилт / Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/-ын ажил

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-20/0113-1

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Багц №1: Сургуулийн гал тогооны тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг татаж үзнэ.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ.

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

Эсвэл

БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийг 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 10 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mn цахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 4 ДҮГЭЭР ХОРОО, БАГА ТОЙРУУ-15, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ 4 ДҮГЭЭР БАЙР, 10 ДУГААР ДАВХАР, НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР, УТАС: 75757810

SKY GARDEN
Kids first RESIDENCE

SKY GARDEN

Дэлхийн барилга, архитектурын салбарт вертикал буюу босоо чиглэлд хөгжүүлсэн ногоон байгууламжийг **Sky Garden** хэмээн нэрийддэг бөгөөд энэхүү шийдлийг төлөвлөлтөнд тусгаснаар өндөр түвшний барилгад байгалийн мэдрэмжийг бодитоор хүртэх боломжийг бүрдүүлсэн.

VERTICAL GARDEN • BOSCO

Sky Garden Residence...
Yet within, peace and calm prevails.

8 True Luxury
ЗӨВ ТАНСАГЛАЛ

Сэтгэлд нийцэх "Байршил"
Ногоон бүсийн үнэ цэнэтэй байршил, 180-360 градус харах өнцөгтэй

Ирээдүйгээ хайрласан "Хүүхэд төвтэй төлөвлөлт"
Хүүхдийн эрүүл аюулгүй хөгжих орчин

Winter Garden Дөрвөн улирлын цэцэрлэг
4-н улирлын ногоон байгууламж

Аюулгүй байдлыг бүрэн хангасан "Дугуйн гүүрэн гарц"
Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй холбогдсон аюулгүй гарц

Рашаан түгээх системтэй
Дөрвөн улирлын турш гэртээ рашаанд орох боломж

Чанарын баталгааг амлах "Материалын сонголт"
Дэлхийн шилдэг чанартай материалаар брэнд орчинг цогцлоосон

Бүхнийг цогцлоосон "Sky Park Plaza"
Хүний бүх хэрэгцээг нэг дор цогцлоосон нэгдсэн үйлчилгээний төв

Газар доогуурх зам бүхий "Галерей"
Хотхоны бүх барилга болон үйлчилгээний төв газар доогуураа туннелээр холбогдсон

Борлуулалтын оффис | Sales Office
+ 976 **771 55555**

Борлуулалтын менежер | *Sales manager*
+ 976 **8888 0835, 8888 0836, 8888 0837**

skygarden.mn
info@skygarden.mn

Халуухан цоолборч А.Анужин

Н.Сийлэн, ЗГМ сонин

Энэ удаагийн “Гоо сайхан” буланд цоолборч А.Анужинг онцолж байна. Тэрбээр цоолборч мэргэжилтэй бөгөөд Buddha Jewelry Organics брэндийн нүүр царайгаар ажилладаг. Түүний гоо сайхны нууц нь ус их ууж, ногоон хүнсээр хооллох аж.

- **Биеийн жин:** 50 кг
- **Биеийн өндөр:** 164 см
- **Биеийн харьцаа:** Хэмжиж байгаагүй
- **Орд:** Ихэр
- **Үсний өнгө:** Хар
- **Нүдний өнгө:** Бор
- **Ажил:**Цоолборчин
- **Идэх дуртай хоол:** Махгүй, ногоо ихтэй хоол
- **Дуртай сүрчиг:** Chanel chance Eau tender
- **Дуртай өнгө:** Хар, улаан, бейж
- **Хобби:** Дижитал зураг, метал хөгжим
- **Зорилго:** Хүмүүст итгэх итгэл, урам зориг бэлэглэх. Мөн өөртөө үнэнч байх
- **Дуртай брэнд:** BVLA, Buddha Jewelry Organics
- **Баримталдаг зарчим:** Шударга шулуун, илэн далангүй байх
- **Нууц авъяас:** Массаж бариа хийх
- **Багын хоч:** Хар хэрээ
- **Үзэх дуртай кино:** Apocalypto, Avatar болон баримтат кино
- **Хэлэх дуртай үг:** Ганц л амьдарна. Сөрөг нөлөөгүй бол бүгдийг хийж үз
- **Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ:** Өглөөний цайгаа уудаг
- **Утасны дэлгэцэн дээрх зураг:** Хүүхдүүдийн минь зураг
- **Instagram хаяг:** st_skinny
- **Гоо сайхны ямар бүтээгдэхүүн хэрэглэдэг вэ:** Өөрт тохирсон бүтээгдэхүүн хэрэглэхийг зорьдог Үсэндээ Oribe брэндийг хэрэглэдэг
- **Жингээ хэрхэн барьдаг вэ:** Их ус ууж, ногоо иддэг. Энэ хооллолт дотор сайн цэвэрлэдэг учир жин нэмдэггүй

БҮТЭЭЛЧ ГОО БҮСГҮЙЧҮҮД СУРГАЛТЫН ТӨВ

“Бүтээлч гоо бүсгүйчүүд” сургалтын төв

Мэргэжил бүхэн сайхан. Гагцхүү тэр мэргэжилдээ л эзэн нь болж, эзэмшиж чадна гэдэг амжилт юм. Манай сургалтын төв таныг нас, хүйс харгалзахгүйгээр урьж байна. Таны зурах авьяас болон бүтээлч үйлийг бид хөгжүүлье. Манай сургалтын төвийг төгссөн тохиолдолд ажлын байранд зуучилж өгөх ба мэргэжлээрээ ажиллах хүртэл бид танд туслах болно.

Маникюр, педикюр /7, 14, 21 хоног/
Сормуус суулгалт, хими /7, 14 хоног/
Нүүрний иллэг массаж, арьс арчилгаа /14, 21,хоног/
Вакс зөв хийж сурах сургалт /7 хоног/
Нүүр будалт /14, 21, хоног/
Косметик шивээсний сургалт /21 хоног/
Мөн багц сургалт явуулж байна.

Өглөө 09:00- 12:00
Өдөр 13:00- 15:00
Орой 17:00-20:00
ажиллана.

88016793
Гоо сайхны сургалт
Лиза салон
lisa95916009@gmail.com

Ц.Наранжаргал: Надад итгэсэн хүмүүсийн итгэлийг алдахгүй юмсан гэж хичээж явна

Аав, ээжийнхээ, ард түмнийхээ, хайртай ханийнхаа бахархал дунд амьдармаар байна

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Монголын жүдо бөхийн спортын эмэгтэйчүүдийн хүнд жинд эх орныхоо нэрийг тив, дэлхийн тавцанд тахалж яваа цөөн тамирчны нэг нь олон улсын хэмжээний мастер Ц.Наранжаргал билээ. 2018 оны Азийн наадмаас хүрэл медаль хүртсэний дараа дэвжээгээ түр хугацаанд орхисон тэрбээр өнгөрсөн улсын аваргаар дахин жүдодоо хөл тавьсан юм. Хэвлэлд тэр бүр ярилцлага өгөөд байдаггүй Ц.Наранжаргал мастерын илэн далангүй яриаг сонирхоно уу.

Гэрэл зургийг С.Батсайхан

-Та бол жүдод шинэ хүн биш. Хэсэг хугацааны завсарлагааны дараа их спортдоо эргэн ирлээ. Хэр хүнд байв?

-Яг үнэнийг хэлэхэд маш хэцүү байлаа. Шантарсан, ядарсан, яах гэж буцаад хүрээд ирэв дээ гэж бодох үе хүртэл байсан. Тэгээд жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсний дараа л бага зэрэг урам орсон. Надад боломж байгаа юм байна гэдгийг мэдэрсэн. Улсын аваргад барилдаж байхдаа өөрийгөө тэгтлээ суларчихаагүй, муудчихаагүй юм байна гэж бодсон. Ер нь хүүхдээ төрүүлээд амарч байх хугацаанд олон хүн намайг дахин барилдахыг зөвлөсөн, ятгасан. Монголын жүдо бөхийн холбоо, шигшээ багийн дасгалжуулагчид болон "Женко" клубын багш нар маань маш их дэм болсон. Улсын аваргад түрүүлбэл үндэсний шигшээ багт авна гэж хэлсэн юм. Би ч боломжийг алдахгүйн тулд өөрийгөө бүрэн дайчилсаны хүчинд улсын аваргад түрүүлж, нэг их удалгүй шигшээ багийн тамирчин болсон. Шигшээ багтаа орж цалин мөнгөтэй золгоно гэдэг амьдралд том нэмэр шүү дээ. "Женко" клуб маань намайг жирэмсэн байхад ч цалинг минь тогтмол өгч байлаа. Магадгүй тухайн үед намайг жүдодоо эргэн ирнэ гэж бодсон учраас цалинг минь таслахгүй өгч байсан болов уу. Тэднийхээ дэмээр би өнөөдөр дахин барилдаж байна. Хэрвээ ийм боломж олгоогүй бол би өдийд жүдог орхисон ч байж мэднэ.

-Хоёр жил гэдэг бага хугацаа биш. Энэ хооронд огт бэлтгэл хийгээгүй хүн төсөөрсөн байдаг шүү дээ. Таны хувьд?

-Бэлтгэлдээ орсноос хойш ердөө гурав хоногийн дараа самбо бөхийн улсын аваргад түрүүлсэн юм. Тэгээд түүнээс долоо хоногийн дараа жүдогийн улсын аварга болсон. Бүр шилдэг тамирчнаар тодорч билээ. Ер нь нэлээд төсөөрсөн байсан. Хөлөө ч хаана гишгэж байгаагаа мэдэхгүй. Гэхдээ 15 жил хичээллэсэн хүн туршлагаараа дотоодын том тэмцээндээ түрүүлж чадсан. Биеийн хүчнээс гадна сэтгэл зүй их нөлөөлсөн шүү. "Хэдийгээр төрсний дараа барилдаж байгаа ч би бусдыгаа бодвол олон жилийн туршлагатай шүү гэж бодсон. Цаашлаад самбоор түрүүлж чадсан юм чинь жүдогоор яагаад чадахгүй гэж" гэсэн сэтгэл зүйн асар том бэлтгэлтэй байсан учраас би дотоодын хоёр том тэмцээнд түвэггүй түрүүлсэн болов уу. Энэ жилийн улсын аваргад түрүүлээд сэтгэл маш ихээр хөдөлж, өөрийн эрхгүй баярын нулимс унагасан. Өмнө нь өчнөөн л түрүүлсэн. Гэхдээ энэ жилийнх шиг тэгж их сэтгэл хөдөлж байгаагүй. Түрүүлээд зогсохгүй шилдэг жүдочоор зарлахад өөрийн эрхгүй огшсон шүү.

-Хоёр жил завсарлаад тэмцээнд ороход арай өөр бодол, сэтгэхүйтэй болсон байна биз?

-Тэгэлгүй яах вэ. Тэс өөр болдог юм билээ. Хэрвээ би улсын аваргад түрүүлж чадахгүй бол спортоо бүрмөсөн орхиж, залуу тамирчдадаа зайгаа тавьж гэсэн бодолтой байлаа. Гэтэл түрүүлсэн учраас өөртөө итгэлтэй болсон. Дээрээс нь бүрмөсөн зодог тайлсныхаа дараа харамсахгүйн тулд эргэн ирсэн юм. Хүн харамсдаг юм билээ. Өдий олон жил жүдогоор барилдсан хэрнээ олимп, дэлхийн аваргаас медаль авч чадалгүйгээр зодог тайлна гэж бодохоор харамсалтай санагдсан. Тиймээс ямар ч байсан өөрийгөө дайчилж, боломжоо ашиглахыг хүссэн юм.

> **ОЛОН ЖИЛ ЖҮДОГООР БАРИЛДСАН ХЭРНЭЭ ОЛИМП, ДЭЛХИЙН АВАРГААС МЕДАЛЬ АВЧ ЧАДАЛГҮЙГЭЭР ЗОДОГ ТАЙЛНА ГЭЖ БОДОХООР ХАРАМСАЛТАЙ САНАГДСАН. ТИЙМЭЭС ХАРАМСАХГҮЙН ТУЛД ЭРГЭН ИРСЭН.**

-Эргэн ирэхэд хамгийн хэцүү байсан хүчин зүйл юу вэ?

-Хүүхэд харах хүнгүй байх л хэцүү санагдсан. Харин одоо бол хоёр ээж минь хүүхэд харж, ар талыг найдвартай дааж яваа учраас санаа зовох зүйлгүйгээр бэлтгэлээ хийж байна. Ээж болсон найзуудынхаа зовлонг өөрөө ээж болсон хойноо л бүрэн ойлгож байна даа.

-Эргээд спортдоо орохдоо хэр их эсэргүүцэлтэй тулгарав?

-Эхэндээ ээж дургүйцсэн. Бас миний хань дуртай байгаагүй. Хүн хамгийн түрүүнд үр хүүхдээ л боддог юм билээ. Хүүхэд жаахан байхад орхиж тэмцээн орлоо, хүүхдээ өсгөж том болго. Чи ер нь залуу хүүхдүүдэд хожигдож онигоо болох хэрэг байгаа юм уу гэх мэтээр зөвшөөрөхгүй байсан. Харин би нөхөртэйгээ ганц л тохироо хийсэн. "Намайг самбо, жүдогийн улсын аваргад оруулчих. Түрүүлбэл миний бэлтгэл хийхийг, цаашид тэмцээнд оролцохыг битгий хоригло. Түрүүлж чадахгүй бол би сайн дуураараа спортоо орхино" гэдэг дээр тохиролцсон. Ингээд би хоёуланд нь түрүүлж чадсан учраас одоо эсэргүүцэхээ больсон. Харин ч дэмжиж байна. Тэмцээн, уралдаанд явахад хоёр ээжээс гадна нөхөр маань хүүхдээ маш сайн хардаг. Гэхдээ хүний л ээж болсон хойно хаана ч явсан хүүхдээ санаж, санаа зовдог юм билээ.

-Их спортдоо эргэн ирснээс хойш анхны том тэмцээндээ оролцлоо. Тэр нь Парисын "Их дуулга" байсан. Энэ тэмцээний талаар дурсах уу?

-Сандарч үзээгүйгээрээ сандарсан, ядарсан, шантарсан. Тийм л тэмцээн болж өнгөрсөн дөө. Дэвжээн дээр гараад юу хийж байгаагаа ч мэдэхгүй байлаа. Хүүхдээ санахын хажуугаар ядарч, шантарч уйлж хүртэл үзлээ. Уйлж байхдаа "Би энд юу хийж яваа юм. Яагаад өөрийгөө ингэж зовооно вэ. Гэртээ хүүхдээ хараад, эрхлүүлээд хэвтэж байхгүй юунд дурлаж энэ хол замыг туулан ирэв" гээд л өөртэйгээ ярьж үзсэн. Тухайн үед хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Д.Сумъяа найз минь миний зүрхэнд итгэлийн галыг асааж өгсөн. Найзаасаа асар их урам зориг авсан шүү. Хэрвээ Д.Сумъяа маань байгаагүй бол тэр чигээрээ шантраад карьераа дуусгах ч байсан юм билүү, мэдэхгүй байна. Харин одоо бол бэлтгэлээ эрч хүч авч байна шүү дээ. Юун ядрах, шантрах. Улам л эрч хүчтэй болсноо мэдэрдэг. Тэмцээн хурдан болоосой л гэж бодох боллоо.

-Хоёр жилийн дараа дахин их спортдоо эргэн ирсэн Наранжаргал сандрахын зэрэгцээ баярласан болов уу. Тухайн үеийн сэтгэл хөдлөл ямар байсан бэ?

-Баярлалгүй яах вэ. Хамгийн гол нь надад итгэл өгч, том тэмцээнд авч явсан шигшээ багийн дасгалжуулагч нар их хүч өглөө. Намайг тэд заавал тэмцээнд явуулах албагүй. Хоёр жил завсарласан хүн форм муутай л байж таарна. Гэтэл тэр бүхнийг ажрахгүйгээр надад итгээд, намайг аваад явсан нь өөрөө маш том урам өгч байгаа хэрэг. Тиймээс үүнд их баярладаг. Ер нь надад итгэл хүлээлгэсэн олон хүн бий. Тэднийхээ итгэлийг л алдахгүй юмсан гэж хичээж явна. Итгэлийг нь алдахгүйн тулд өдөр бүр бэлтгэлээ эрч хүчтэйгээр хийж байна.

-Тэгвэл та спортоос хөндийрч байхдаа өөрийнхөө орон зайг алдахаас айж байсан уу?

-Миний биеийг төмрөөр хийгээгүй учраас би нэг л өдөр спортоо орхих нь тодорхой. Тиймээс миний араас залгамжилж буй дүү нар хурдан гарч ирээсэй гэж боддог. Намайг завсарлаж байх хугацаанд орлох өөр тамирчин гарч ирээд, би түүнийг үнэхээр дийлэхгүй бол зайгаа тавиад л өгнө. Надад тийм сэтгэл зүй байна. Хүний орон зайг булаах хүсэл ч байхгүй. Харин тухайн тамирчнаа тултал нь дэмжинэ. Түүнээс биш би заавал байх ёстой гэж зүтгэхгүй. Чадахгүй байгаа учраас, надаас илүү тамирчин гарч ирсэн учраас зайгаа тавьж өгөх нь миний үүрэг юм. Ийм бодолтой явдаг тул орон зайгаа алдахаас айгаагүй. Тиймээс жингийнхээ дүү нарыг цаг хугацааг сайн ашиглаж, бэлтгэл тултал нь хийж дэлхийн дэвжээнд амжилт үзүүлээсэй гэж хүсдэг.

-Коронавирусийн хорио цээр зарим тамирчинд хүнд туссан байх. Гэтэл нэг хэсэгт нь маш том боломж олголоо гэж харж байна. Тэр тамирчдын тоонд та ч бас орно. Харин та надтай санал нийлэх үү?

-Шигшээ багийн дасгалжуулагч Ч.Болдбаатар багшдаа "Хүмүүс коронавирусийг үзэж ядаж байна. Харин надад боломж олгосон юм шиг санагдаад эергээр хүлээж авч байгаа" гэсэн чинь багш "Чамд зориулаад олимп нэг жилээр хойшиллоо" гэж хэлсэн юм. Тэр үг миний толгойд шууд орж ирсэн. Энэ цаг хугацаа, орон зайг ашиглаад бэлтгэлээ сайн хийхийг эрмэлзэж байна. Надад маш том боломж олгож байна гэж харж

байгаа. Хэрвээ хорио цээрийн дэглэм тогтоогоогүй байсан бол би 2020 оны олимпод оролцож амжихгүй ч байж мэднэ. Ядаж л багийн барилдаанд оролцож, нэг ялалт авах юмсан гэж чин сэтгэлээсээ хүсч, мөрөөдөж явлаа. Багийн барилдаанд бүхнээ дайчилдаг нь миний унаган зан юм. Тэгвэл одоо хувийн амжилтаа ч, багтаа ч том хувь нэмэр оруулах боломж нээгдэж байна.

-Гурван Азийн наадмаас дараалан медаль авсан жүдоч Монголд танаас өөр байдаггүй юм билээ. Тэгэхээр олимп, дэлхийн аваргаас медаль аваад зодог тайлаасай гэж хүсдэг хүмүүсийн нэг нь би юм. Дээр дурдсан хоёр тэмцээн таны ойрын зорилго мөн биз?

-Тэгэлгүй яах вэ. Зөвхөн олимп, дэлхийн аварга гэлтгүй дахиад нэг удаа Азийн наадамд зодоглох юмсан гэж шунаж байна. Тэгэхээр боломж гарвал 2022 оны Азийн наадамд барилдах хүсэлтэй. Мэдээж нэн түрүүнд олимпын эрхийн оноогоо цуглуулах хэрэгтэй. Азийн аваргад түрүүлмээр байна. Дараа нь олимпоос медаль авах тухай ярих нь зөв болов уу. Ямар ч байсан дээр дурдсан тэмцээнүүдэд амжилт үзүүлэхийн төлөө хичээх болно. Олимп, дэлхийн аваргаас медаль авч чадалгүй зодог тайлбал зөвхөн би ч биш миний эргэн тойрныхон, намайг дэмждэг ард түмэн харамсах биз. Тиймээс харамсахгүйн тулд бүхнээ зориулна даа. Би нэг л зүйлээс айж байна. Тэр нь надад итгэж байгаа энэ олон хүний итгэлийг алдах вий, урмыг нь хугалах вий гэдгээс айж байна.

-Ер нь та богино хугацаанд хувийн амьдралдаа өөрчлөлт хийж чадсан байна шүү. 2018 оны Азийн наадмаас медаль авсны дараа гэхээр?

-Азийн наадмын дараа дэлхийн аваргад оролцсон. Тухайн жилийн дэлхийн аваргаас медаль авах юмсан гэх том зорилготой байлаа. Тэр хэрээр биеэ барьж, сандарсан. Ингээд тэмцээнээ дуусгасны дараа өдий олон жил барилдсан хэрнээ олимп, дэлхийн аваргаас медаль авч чадаагүйдээ сэтгэлээр унаж, гутарсан. Тэгээд ер нь л спортоо орхиж, өөрийнхөө боловсролд анхаарч, хөгжүүлье гэж бодсон. Том тэмцээнүүд дуусан учраас хэсэг хугацаанд тархи толгой, биеэ амраахаар шийдсэн. Тэр амралтын үеэр л хүүхэд минь бэлэг болж ирсэн байсан, маш их баярлаж хүлээн авсан. Жирэмсэн болсон хойноо дахиж барилдахгүйгээр шийдсэн ч үүнээс өөр чадах зүйл байгаа билүү гэж бодсон. Монголд үнэндээ барилдахаас өөрөөр ажил хийж амьдарч чадахгүй юм билээ. Тиймээс амжилтад хүрээд, сайхан амьдрахыг хүсч байна. Юуны төлөө махбодио, амьдралынхаа хагасыг зориулсан билээ. Эх орныхоо төлөө, сайхан амьдрахын төлөө л золиос гаргаж байна. Амжилтаа үзүүлж чадвал эх орон, аав, ээж, ард түмэн, хань ижил гээд бүгдээрээ л бахархана. Олон хүний бахархал дунд амьдарч, хүнд хайрлагдан, түүнээсээ таашаал авна гэдэг чинь хамгийн том аз жаргал биз дээ.

Юуны тулд махбодио, амьдралынхаа хагасыг золиослосон билээ. Олон хүний бахархал дунд амьдарч, хүнд хайрлагдан, түүнээсээ таашаал авна гэдэг чинь хамгийн том аз жаргал биз дээ.

-Ингэхэд жүдоч болоход таны бөхийн удам нөлөөлөв үү. Эсвэл та өөрөө тэгтлээ дурлаа юу?

-Би "Молиго бүргэд"-ийн хэмээх 1932 оны наадмын түрүү бөх, улсын арслан П.Бат-Очирын удам юм билээ. Аав минь тэр хүний зээ хүү. "Молиго бүргэд" гэх хүн 43 насандаа улсын наадамд түрүүлсэн. Тэгвэл энэ удмын бөх улсын начин А.Алтанхуяг ч мөн 40-өөд насандаа улсын цол авсан шүү дээ. Тэр утгаараа манай удмынхан нас тогтсон хойноо амжилт гаргадаг юм байна гэх бодол төрсөн. Харин миний амжилт гаргах нас одоо л болж байх шиг. Ийм бодол өөрийн эрхгүй төрж, өөрийгөө тайтгаруулж явдаг. 2004 оноос жүдод хөл тавьсан. Тухайн үед спортын төв ордны хоёр давхарт нэг заалны хаалга онгойлгоход Ш.Цэвэлмаа багш угтсан. Аав минь миний ихэр Нарантогтох бид хоёрыг дагуулж очиж, багшид шавь оруулж байлаа. Энэ цагаас хойш л хоёргүй сэтгэлээр жүдод зүтгэсний ачаар чамлахааргүй амжилт гаргалаа. Одоо олимп, дэлхийн аваргаас л медаль авах үлдсэн дээ. Миний ихэр Нарантогтохын хувьд байлдааны самбоор багагүй амжилт үзүүлсэн.

-Эмэгтэй хүүхдийг барилдана, бокс тоглоно гэхээр эцэг, эхчүүд дургүйцдэг. Таны аав, ээж бас тэдний нэг байсан уу?

-Анхнаас нь л дэмжиж ирсэн. Ямар сайндаа л аав минь намайг анх барилдаж эхлэхэд өглөө бүр гүйлгэж, хичээлд явахаас өмнө өглөө бүр гар дээр суниалт 50, гэдэс таталт 50, нуруу таталт 50-ыг хийлгэдэг байлаа. Аав минь 10 гаруй жил энэ дасгалаа хийлгэсэн дээ. Бас уул өөд гүйлгэнэ. Ер нь багш шиг л бэлтгэл хийлгэнэ. Монголд болсон бүхий л тэмцээнд дагаж явна. Аав, ээжийнхээ дэмжлэгийн хүчинд л би өдий зэрэгтэй яваа юм. Манай жүдочдын олонх нь миний аавыг мэднэ.

-Тэмцээн болохгүй ч бэлтгэлээ тогтмол хийж байгаа байх. Өдрийн хэдэн цагийг бэлтгэлд зарцуулж байна вэ?

-3-4 цагийг хүчний бэлтгэлдээ зарцуулж байна. Жүдогоор барилдахын тулд хүчний бэлтгэл маш чухал. Тиймээс Golds клубт Б.Мөнхбаяр багшийнхаа удирдлага дор хүчний бэлтгээл базааж байна. Багшийнхаа ачаар хүч маань ахиж, бэлтгэл ч их таарч байгаа учраас баярлалаа гэж хэлье. Харин шигшээ багийнхантайгаа нэгдэж чадаагүй л байна. Тэд хөдөө цугларалтад гарсан байгаа. Би удахгүй араас очно. Ар гэртээ санаа зовохгүйгээр бэлтгэл хийх нь чухал. Тиймээс хүүхэд харах хүнтэй болсны дараа шигшээ багийнхаа жүдочидтой нэгдэнэ.

-Цаг гарган ярилцсанд баярлалаа. Хүссэн зорилгодоо хүрч олимп, дэлхийн аваргаас медаль авахыг хүсье?

-Баярлалаа. Намайг өнөөдрийг хүртэл дэмжсэн гэр бүлийнхэн, Монголын жүдо бөхийн холбоо, "Женко" клуб, шигшээ багийнхан, Golds клубын хамт олон, дасгалжуулагч Г.Энхбаяр, Ш.Цэвэлмаа, хүчний багш Б.Мөнхбаяр, шигшээгийн дасгалжуулагч нартаа маш их баярлалаа гэж хэлье. Та бүхний надад итгэсэн тэр их итгэлийг амжилтаар хариулж, дааж явахын төлөө хичээх болно. ■

Ц.Наранжаргал бол Азийн гурван олимпоос дараалан медаль хүртэж чадсан цорын ганц монгол жүдоч юм.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: XVII.1.168 "Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 10 ор /Архангай, Ихтамир сум/" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ЭМЯ/202001024

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос XVII.1.168 "Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 10 ор /Архангай, Ихтамир сум/" ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.0 (тавин мянга) төгрөгийг банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер нь дараах багцаас бүрдэнэ: Багцгүй.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна.

Ижил төстэй ажилд барилга угсралтын ажил гүйцэтгэсэн туршлагыг тооцно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил

БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ. 10,000,000.00 (арван сая) төгрөг

Тендерийг **2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 09 цаг 10 минутад** Төрийн худалдан авах ажиллагааны газарт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn цахим хуудаснаас бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А, ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260115, 260056
Цахим хаяг: www.tender.gov.mn

ZGM DAILY

TDB and UBC bank consolidated

TDB will further serve all UBCB clients following the consolidation approved by the Bank of Mongolia on June 23, 2020.

Members of new parliament officially receive ID cards

In line with the General Election Commission's (GEC) statement, no discrepancies have been reported in the 164 polling stations.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

On the occasion of the 50th anniversary of the establishment of diplomatic relations between Mongolia and the Italian Republic, President Battulga Khaltmaa and Minister of Foreign Affairs Tsogtbaatar Damdin exchanged letters of congratulations with their Italian counterparts, Italian President Sergio Mattarella and Foreign Minister Luigi Di Maio.

ECONOMY

Top 20 index drops 0.23 percent, to 16,123.55 points. MSE A index increases 0.09 percent, to 7,996.22 points. MSE B index rises 1.15 percent, to 7,367.66 points. Market cap stands at MNT 2.45 trillion.



SOCIETY

Ulaanbaatar Taxi Cab and UB Cab LLCs to put at least 1,000 left-hand vehicles that meet local taxi service standards into service within 2020. As part of the efforts to improve taxi service in Ulaanbaatar, Ulaanbaatar Taxi Cab LLC has been formed under Ulaanbaatar Development Corporation JSC.

he virtual meeting of the 135th/136th Sessions of the WCO Council was held with the attendance of the heads of customs administrations of 183 countries. The notable feature of this meeting was that the delegations submitted their proposals in advance for discussion.

The organizing committee of the Naadam Festival allows authorities of each province and soum to hold their local Naadam celebrations with public attendance on July 11-12. However, the committee ordered provinces to organize the festivities with strict COVID-19 safety measures in place.

Rio Tinto reaches agreement on domestic power supply with Mongolia for OT

Rio Tinto will amend its current power supply agreement with the Mongolian government by March 2021

Bayartsetseg.D, ZGM Daily

Rio Tinto Ltd had reached an agreement with Mongolia to domestically supply power to its Oyu Tolgoi copper-gold mine through a state-owned coal-fired power plant at Tavan Tolgoi, the company reported on Monday. The Government of Mongolia owns 34 percent in the Oyu Tolgoi project, while Rio Tinto's majority-owned Turquoise Hill Resources (TRQ) has a 66 percent stake in the project.

The mining giant said in a statement it will amend its current power supply agreement with the Mongolian government by March 2021, under which the government will begin construction of the coal-fired power plant by July 2021. The plant, being built to supply power to the Oyu Tolgoi project, is expected to be commissioned within the next four years. Until the commissioning of the state-owned plant, power supply to the mine and the underground project will continue under the current terms.

In March, Rio had flagged slowing down operations at the Mongolian mine due to coronavirus restrictions. Mongolia and Oyu Tolgoi LLC reached an agreement on the State-owned power plant, Turquoise Hill Resources and Rio Tinto announced Sunday, affirming the April decision by the Mongolian cabinet over the power supply for the mine. Mongolia will fund and construct the power plant at Tavan Tolgoi, while the existing power source agreement was amended. The power plant will deliver "reliable" power for open-pit operations and project development Turquoise Hill Resources said.

> **TRQ's share price has been heavily volatile amid the successes and struggles at OT, last year rising significantly on positive developments.**

TRQ's share price has been heavily volatile around the successes and struggles at Oyu Tolgoi, last year rising significantly on positive developments while plummeting by nearly half just months later. OT currently uses imported power and both the Government of Mongolia and Oyu Tolgoi have committed to extending the current arrangement to ensure continued stable power is supplied to the mine and underground project until the State-Owned Power Plant is commissioned and is able to supply stable, reliable and continuous power.

Arnaud Soirat, Copper and Diamonds chief executive of Rio Tinto Ltd, said, "This agreement provides a potential pathway to securing a domestic power supply for the Oyu Tolgoi mine and underground project for the benefit of all shareholders and the wider community. We look forward to working with the Government of Mongolia to progress the solution." ■

STOCK MARKET



POLITICS

Members of new parliament officially receive ID cards



Bayartsetseg.D, ZGM Daily

Newly elected parliamentary members were handed over ID cards on June 29 in the government house of Mongolia. Moreover, in line with the General Election Commission's (GEC) statement, no discrepancies have been reported in the 164 polling stations. Following the June 24 polls, a census was carried out in 846 polling stations or 42 percent of the 2,070 polling stations nationwide.

This is mainly driven by parties, coalitions, and candidates who have filed complaints with the President and the General Election Commission regarding the results of the 2020 parliamentary elections. In accordance with the President's obligations to the General Election Commission, an additional manual census was conducted in the five provinces and five district polling stations mentioned in the requirement. These include 22nd - 23rd constituencies of Bayanzurkh district, Chingeltei, Sukhbaatar, Songinokhairkhan, and Khan-Uul districts, as well as the first constituency of Arkhangai province, the 7th constituency of Dornod province, the 10th district of Uvurkhangai province, the 11th district of Umnugovi province also, the 19th district of Darkhan-Uul province. ■

Avergae age of MPs lowered by 0.8 years since 2016

The average age of the previous 76 members of the Parliament was 47.4, while the average age of the current MPs stood at 46.6.

79.8 percent of the previous MPs were 41-59 years old, but this time they make up 84 percent of the Parliament. However, 11.8 percent are in their 30s and 40s, indicating that they are slightly younger than in the previous Parliament. ■

SOCIETY

Mongolia reports one more COVID-19 case

National Center for Communicable Diseases (NCCD) announces the current situation of the COVID-19 outbreak during the Ministry of Health's daily briefing. On June 28, a total of 216 people were tested at three laboratories nationwide. Among them, one person was tested positive for the novel coronavirus. **A Mongolian citizen, who was repatriated from Kazakhstan on June 10, was tested positive for the coronavirus as a result of his third repeated testing or after 19 days.**

According to the NCCD, retesting of 181 citizens who were isolated in the observation room, two surveillance tests, 14 truck drivers who entered through Altanbulag border checkpoint, and four people isolated in Selenge province revealed negative for COVID-19. Additionally, 220 cases confirmed in Mongolia of which 175 have been cured. Currently, 45 people are being treated at the NCCD, 36 of them are in mild condition and nine are in severe condition. ■

BANKING

TDB and UBC bank consolidated

Aminaa.U, ZGM Daily

All assets, liabilities, equities, and branches of Ulaanbaatar City Bank (UBCB) will be consolidated into the Trade and Development Bank (TDB), taking effect from June 29th, the TDB announced on Monday. **TDB will further serve all UBCB clients; Bank of Mongolia approved the consolidation on June 23, 2020.**

Ulaanbaatar City Bank, named after the capital of the country, has been operating successfully for 21 years since 1999, professionally and swiftly providing comprehensive banking and financial services to its customers. The bank has been proudly making the list of the TOP-100 enterprises, announced by the MNCCI every year, as well as is one of the six systemically important banks in the banking system, as defined by the Bank of Mongolia.

Strengthened human resources, expanded customer base, and adequacy of bank branches significantly contribute to achieving our strategic goal of closely serving our customers, TDB said in an announcement.

Mr. Orkhon Onon, Chief Executive of Trade and Development Bank talked about further operations on the merge of the banks.

-Two influential banks have officially consolidated in the banking system. Could you provide the related information on this?

-About Trade and Development Bank (TDB) and Ulaanbaatar City Bank, both have over 20 years of experience in the market and they have combined operations on June 29. It can be named a historic event. In accordance with the permission issued by the Bank of Mongolia (BoM) on June 23, 2020, all assets of Ulaanbaatar City Bank together with the branch and settlement center have been merged with the Trade and Development Bank.

-More interestingly, the two merged banks both have a potent and authoritative status in the banking system.

-Of course, that is why I called this event momentous. In the past period, such a large corporation has never appeared in the banking system. Both two banks have large scales. Additionally, defined by the Bank of Mongolia, two systemically important banks with more than 5 percent of the banking sector have joined on a voluntary basis. It is the very first combination of TDB.

The Trade and Development Bank and Ulaanbaatar City Bank, both have over 20 years of experience in the market, have combined operations on June 29. It can be called a historic event.

-How will customers feel about this merging process and what is the further plan?

-Presumably, TDB's primary capital is customers and we have arranged and prepared all procedures for customers to accept this change in the easiest and clearest way. In other words, all clients and partners will be customers of the Trade and Development Bank from June 29 without touching the services and conditions of Ulaanbaatar City Bank. As a result of the influential bank combination in the banking system, the Trade and Development Bank has expanded to 400 employees, 33 branches and settlement centers, and more than 1,900 merchandising organizations. This activity is beneficial for both sides as well. ■

Хөл хорио хавдартай өвчтөнүүдийг бухимдуулж байна

Таван хүн тутмын нэг нь Улсын онцгой комиссын хөл хорио эмчилгээнд нөлөөлсөн хэмээн хариулжээ

Б.Гандолгор, ЗГМ Сонин

Энэ цагийн хамгийн хэцүү өвчин бол хорт хавдар. Манай улсад жил ирэх тусам хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, залуужиж байна.

2018 онд гэхэд 6073 хүн хавдартай болох нь оношлогдож, 4412 хүн хорт хавдрын улмаас нас барсан гэсэн статистик гарчээ. Харин 2019 онд 6045 хүн хавдраар өвчилж эмнэлэгт ханджээ. Дэлхий даяар тархсан цар тахал зарим хавдартай өвчтөнийг сэтгэл зүйн дарамтад өртүүлж байна. Энэ талаар Хавдрын үндэсний зөвлөлөөс судалгаа хийжээ. Тус байгууллага хавдартай өвчтөн, тэдний асран хамгаалагч нараар COVID-19 -тэй холбоотой нөхцөл байдлыг үнэлэх тест бөглүүлсэн байна. Үүнд 179 хүн хамрагдсан бөгөөд тэдний 39.1 хувь нь хорт хавдартай өвчтөн, 60.9 нь өвчтөний асран хамгаалагч байжээ. **COVID-19-ын үеийн хөл хорио, хязгаарлалтын арга хэмжээ нь хавдартай өвчтөн ба тэдгээрийн асран хамгаалагч нарын 31 хувийнх нь сэтгэл санааны байдалд нөлөөлсөн нь судалгаанаас харагджээ.**

ОРОН НУТАГТ ХИМИЙН ТАРИА ТАСАРСНААС БОЛЖ ХОТОД ИРЭХ ШААРДЛАГА ГАРСАН ГЭЖ ХАРИУЛСАН БАЙНА.

Мөн дөрвөн хүн тутмын нэг нь хэдэн өдрийн турш, 10 хүн тутмын нэг нь бараг өдөр бүр бухимдаж, сэтгэл санаа тогтворгүй байдаг хэмээн хариулсан байна. Түүнчлэн таван хүн тутмын нэг нь Улсын онцгой комиссын хөл хорио эмчилгээнд нөлөөлсөн хэмээн хариулжээ. **Зарим хүний эмчилгээний цаг хойшилсон, эмнэлэгт оруулахгүй болсноор эмчтэйгээ уулзаж чадахаа байсан, орон нутагт химийн тариа тасарснаас болж хотод ирэх шаардлага гарсан гэж хариулсан байна.** Судалгаанд оролцсон иргэний 63.1 хувь нь санхүүгийн хямралд өртжээ. Цаашид хэрхэх нь ойлгомжгүй байгаа болохоор сэтгэлийн түгшүүртэй байгаагаа 45.3 хувь нь илэрхийлсэн байна. ■

45-69 насныхны 51 хувь нь халдварт бус өвчнөөр өвдөх эрсдэлтэй

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгааны талаар судалгаа хийснээ өчигдөр олон нийтэд танилцууллаа. Тус судалгаанд 6600 гаруй иргэнийг хамруулсан байна. Сүүлийн жилүүдэд урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчин хүн амын дунд түгээмэл байгаа нь тулгамдсан асуудал болжээ. НҮБ-ын төрөлжсөн агентлагаас 2016 онд хийсэн судалгаанаас монголчуудын нас баралтын 77 хувийг халдварт бус өвчин эзэлж буйгийн дотор 32 хувь нь 30-70 насныхан байна.

Энэ удаагийн судалгаанаас харахад халдварт бус өвчнөөр өвчлөх эрсдэлгүй бүлэг нь хүн амын 3.9 хувийг эзэлж байгаа нь эрүүл мэндийн салбарынхны санааг чилээсэн асуудал болов. Архи, тамхины шалтгаант эмгэг, хөдөлгөөний хомсдол, таргалалт, илүүдэл жин гэзэг хүн амын 22.7 хувь халдварт бус өвчнөөр өвдөх эрсдэлтэй гэсэн судалгаа гарчээ. Мөн 45-69 насны иргэдийн талаас илүү нь буюу 51.2 хувь нь халдварт бус өвчнөөр өвчлөх өндөр эрсдэлтэй гарсан нь судлаачдын анхаарлыг татжээ.

ДЭМБ-аас зөвлөсөн давсны хэрэглээг бууруулах стратеги үр дүнтэй байгаа ч баруун бүсийнхэн хэрэглээгээ хоногт таван грамм буюу стандарт түвшинд хүртэл бууруулах шаардлагатайг онцоллоо. ■

ЗӨВЛӨГӨӨ

Гэртээ чийгшүүлэгч хэрэглэж, харшлаас сэргийлээрэй

Улаанбаатар хотын иргэдийн 68.3 хувь нь шарилж, лууль, согоовор, ерхөг, хус, улиас зэрэг ургамлын тоосны шалтгаант харшилтай байна. Эдгээр ургамлын тоосны харшил нь зургадугаар сарын сүүлчээс наймдугаар сарын дунд үе хүртэл идэвхждэг. Ургамлын үрийг боловсрохоос нь өмнө тайрч харшил өдөөхөөс сэргийлнэ. Шарилж, лууль зэрэг ургамлыг наймдугаар сарын дунд үе хүртэл гурван удаа тайрах хэрэгтэй. Ингэснээр ургамлын тоосны хэмжээ буурдаг.

Харшлаас хамгаалахын тулд машин болон гэртээ агаар чийгшүүлэгч хэрэглэх, угаасан хувцсаа гадаа хатаахгүй байх, амны хаалт зүүж явахыг зөвлөе. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 06 дугаар сарын 30

Тендер шалгаруулалтын нэр: **“Ажилчдын эрүүл мэндийн үзлэг”.**
Тендер шалгаруулалтын дугаар: **МИАТ/202002159**

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос: **“Ажилчдын эрүүл мэндийн үзлэг”** хийж гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа хялбаршуулсан цахим тендер тул http://www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй гэрээ байгуулж ажилласан байх ба гэрээний хуулбарын хамт ирүүлнэ.

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна /2018, 2019он/

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна

Тендерийн хамт төсөвт өртгийн 2 хувьтай тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10.00 цаг**-аас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 10.10 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр Хангамж, үйлчилгээний хэлтсийн 117 тоот өрөө, www.tender.gov.mn
Утас: 70049860, Факс: 70049919

ӨРНИЙН ЗУРХАЙ

Охины ордынхон санхүүгийн байдлаа анхаар

Хонь /III.21-IV.19/

Харилцааны тал дээр асуудал тулгарч магадгүй. Ширүүн ааштай, бүхнийг өөрийн зөв гэж зүтгэдэг нэгнээс болж ажлын орчинд томоохон маргаан дэгдэж болзошгүй. Аливаа таагүй нөхцөл байдлыг тэвчээртэй, ухаалаг, тайван байдлаар даван туулаарай. Сэтгэлийн хөөрлөө дарж, бясалгал хийж залбир.

Мэлхий /VI.22-VII.22/

Мэргэжлийн бус зүйлээ мэддэг юм шиг хийх хэрэггүй. Танд огтхон ч сайн нөлөө авчрахгүй ажлаас эртхэн татгалзах хэрэгтэй. Хувийн амьдралд бага зэргийн хямрал үүсэж мэдэх ч зөв хөдөлж, ухаалгаар сэтгэж чадвал үүссэн нөхцөл байдлыг амархан дарж чадна. Хайр дурлалын харилцаанд ямар нэгэн саад бэрхшээл багатай, сайхан уур амьсгал үргэлжилнэ.

Жинлүүр /IX.23-X.22/

Хэн нэгний амаар ажил хэргээ явуулах хэрэггүй. Бүхий л зүйлд өөрийн хүчийг дайчлан эрч хүчтэй байдлаа харуулах хэрэгтэй. Туршигдаагүй зүйлийг дур мэдэн хийснээр том алдаа гаргах магадлал өндөр. Бүсгүйчүүд атаа жөтөөнөөсөө болж дэмий зарлага гаргасандаа харамсана.

Матар /XII.22-I.19/

Олон нийттэй холбоотой ажлаас хөндий байж аль болох өөрөө биечлэн хийх ажилд ахиц гаргаарай. Сайн мэдэхгүй хүнд зовлон жаргалаа тоочих хэрэггүй. Таны эсрэг явуулга хийж болзошгүйг анхааараарай. Өнөөдөр аз, бүтэлгүйтэл зэрэг ирнэ. Амьдралаа өөрчилж болохуйц чухал шийдвэрийг ганцаар гаргах хэрэггүй.

Үхэр /IV.20-V.20/

Бүсгүйчүүд зөн билэгтээ итгэхийг хүснэ. Тэд хэт мэдрэг эмзэг байх бөгөөд өчүүхэн зүйлд ч хямарч мэдэхээр байна. Хамтран ажиллахад туйлын таатай. Таны өнөөдрийн хийсэн бүтээл амжилт дагуулах болно. Ахмад настнуудын сэтгэл санаа тогтвортой биш байх бөгөөд даралт ихсэх, толгой эргэх зэргээр тавгүйтнэ.

Арслан /VII.23-VIII.22/

Санхүүгийн хүрээнд бүтэлгүйтэл, ноцтой алдаа гарч магадгүй тул илүү анхаарал болгоомжтой байхыг зөвлөж байна. Мөрөөдөл, бодит байдал хоёроо ялгаж салгаж сурах хэрэгтэй. Эс тэгвэл та маш том эрсдэл үүрч мэднэ. Өөрийгөө хуурч, тайвшруулах хэрэггүй. Ямар ч үед эерэг сөрөг хоёрыг хамтад нь тооцоолж бай.

Хилэнц /X.23-XI.22/

Түншүүдтэйгээ харилцаагаа бататгах, ажлын үр дүнгээ ярилцах, ирээдүйгээ төлөвлөхөд таатай. Сарын сүүлийн өдөр тул дутуу үлдээсэн бүхий л зүйлээ гүйцээж, өмнө хийсэн ажилдаа дүгнэлт хийхэд тохиромжтой. Таныг гэнэтийн бэлэг аз жаргалтай болгоно. Гэр бүлд ямар нэгэн баяр тэмдэглэж, найз нөхөд ойр дотнын хүмүүстэйгээ хөгжилдөнө.

Хумх /I.20-II.18/

Санхүүгийн дэмжлэг хүссэн хүсэлт биелэх болно. Нөлөө бүхий хүмүүс эсвэл хамаатнуудаасаа дэмжлэг авна. Ойр дотнынхны харилцааг сайжруулан, олон хүний дунд зуучлагч гүүр нь байх бололтой. Бизнес болон ажил хэрэгт ямар ч саад бэрхшээл тулгарсан цалгардуулж, үргүй зарлага гаргахгүй байхыг зөвлөж байна.

Хамтатгах /V.21-VI.21/

Бүтээлч, оюунлаг, хөдөлмөрч байдлаараа бусдын анхаарлыг татаж чадсан таны хувьд ахин олон боломж гарч ирэх болно. Та хэн нэгний даган дууриах, үлгэрлэхийг хүссэн хүн нь байж чадна. Өөрийн эргэн тойронд байгаа хүмүүсээ гүйлгэж нэг хараарай. Та бүхий л бололцоогоо дайчлан тусламжийн гараа сунгаж, талархлын үгээ хэлж, зөвлөгөө зөвлөмж өгөх болно.

Охин /VIII.23-IX.22/

Зарим нэг хүний ухаангүй тэнэг үйлдлээс болж санхүүгийн байдал дордоход хүрч болзошгүй. Хийж дадсан ажилдаа бүх хүчээ зориул. Хэт ядрах, ачааллаас болж өвчин тусах магадлалтай. Эд хөрөнгөтэй холбоотой янз бүрийн асуудал гарч болзошгүй. Та гэр бүлийн хүрээнд хувийн асуудлаа шийдвэрлэхийг зөвлөж байна. Асуудлын хүрээг тэлэх хэрэггүй.

Нум /XI.22-XII.21/

Дурын ажил хүссэн үр дүнг авчрахгүй. Шинээр танилцсан хүмүүс амжилтад ихээхэн нөлөө үзүүлнэ. Мэргэ төлөг хийлгэх, бөө удганд очих хэрэггүй. Та зөвхөн өөрийн зөн совиндоо итгэж, харж байгаагаараа бүхнийг шийдвэрлэх гэж хичээ. Хэн нэгэн танаас тусламж дэмжлэг хүсвэл эргэлзэх зүйлгүй туслаарай. Танд хариу нь ирэх л болно.

Загас /II.19-III.20/

Сэтгэл хөдлөлдөө баригдаж хэлсэн үг, хийсэн үйлдэл чинь бусадтай маргаан зөрчилдөөнд оруулж, ихээхэн шуугиан дэгдээхэд хүргэнэ. Энэ нь танд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй өвдөхөд хүргэж болзошгүй. Гайхамшиг тохиож таны хүсэл биелэнэ гэж найдах хэрэггүй. Өөрөө өөртөө эзэн байхыг сануулж байна.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

1. Үрэлтээс үүссэн үйрмэг
3. “Марзан” хочоороо түүхэнд алдаршсан зураач
4. Чингис хаан одонт дуурийн од
7. Швед дэх Монгол Улсын Элчин сайд асан
8. Өвөрмонголын аймаг
10. Энэтхэг улсын Ерөнхий сайд асан эмэгтэй
11. Дугуйт тэшүүр

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Ижий гэсэн хуучин монгол үг
2. Олон янзын өнгөтэй чулуулаг эрдэс
5. Үндэсний үзэл, хандлагаараа буруудан хорлогдсон төрийн зүтгэлтэн
6. Ардын төрийн наадмын анхны түрүү бөх
9. Эвтэй дөрвөн амьтан
10. Европ, Африкийг зааглах хоолой
12. Нийслэлийн ойролцоох олон улсын хүүхдийн зуслан
13. Хоол, хүнс
14. Зарим улс орны мөнгөний нэгж

Өмнөх дугаарын хариу 06.29

		Х	О	Р	О	М		
		О	■	■	■	А		
Д	О	Р	Ж	Г	О	Т	О	В
А	■	О	■	И	■	А	■	А
Л	А	Л	■	Й	■	Д	А	Н
■	■	■	■	Н	■	■	■	■
Х	О	Ч	■	Г	■	Т	А	Х
Ө	■	А	■	О	■	О	■	Ө
Г	О	М	Б	О	Д	О	Р	Ж
		А	■	■	■	Н		
		Р	О	М	Е	О		

ДОРНЫН ЗУРХАЙ

Үс засуулбал эрч хүч ихэснэ

Үс засуулбал:
Эрч хүч ихэснэ.
Наран ургах, шингэх:
04:57-20:55 цаг
Барилдлага: Хүчин төгсөх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй
Суудал: Гал

Аргын тооллын 6 сарын 30, Ангараг гараг. Билгийн тооллын 10, Салхины эх одтой, хөх луу өдөр. Өдрийн наран 4:57 цагт мандан, 20:55 цагт жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч ихсэнэ.

ЗГМ: СУДОКУ

		6	8	9			5	3
		3	4			8		
		7		5	3		6	
				1			9	6
	5			4				8
	2		6		5			
			7	6	4	9		
8		9						
7						3		4

Өмнөх дугаарын хариу

5	6	9	1	8	4	7	3	2
3	1	8	2	7	5	6	9	4
4	2	7	3	6	9	5	1	8
1	5	3	8	4	6	9	2	7
7	9	2	5	1	3	4	8	6
8	4	6	7	9	2	3	5	1
2	3	1	4	5	7	8	6	9
6	8	4	9	3	1	2	7	5
9	7	5	6	2	8	1	4	3

АЛЖААЛ ТАЙЛАХ 18 АСУУЛТ

САЙХАН ХООЛОНД АМАРХАН ДОНТДОГ



Т.Намуунболор, ЗГМ сонин

Энэ удаагийн “Алжаал тайлах 18 асуулт буландаа загвар өмсөгч, жүжигчин О.Амгаланбаатарыг урилаа.

-Сэтгэлээр унасан үедээ юу хийдэг вэ?
-Ууланд алхдаг

-Олны танил эсрэг хүйсийн хүнтэй оройн зоог баривал хэнийг сонгох вэ?
-Төрийн соёрхолт, МУАЖ Н.Сувд

-Өөрийгөө гурван үгээр тодорхойлно уу?
-Түргэн, зөөлөн, тууштай

-Таны хамгийн том алдаа?
-Есөн жил тамхи татаад гарч байсан

-Алдаанаасаа ямар сургамж авсан бэ?
-Хүнд саваагүй зан хэрэггүй

-Хамгийн их хэрэглэдэг апп?
-Facebook

-Юунд амархан донтдог вэ?
-Хоол

-Хэзээ ч орхиж чадахгүй хобби?
-Хүн шоглох, хошигнох

-Таныг цухалдуулдаг зүйл?
-Тодорхойгүй байдал, худлаа ярих

-Таны мэдэх хамгийн загварлаг нэгэн?
-Загвар өмсөгч Э.Энхболд

-Бүх л амьдралынхаа турш ганцхан хувцас өмс гэвэл юу өмсөх вэ?
-Дотоож

-Биедээ байнга авч явдаг зүйл?
-Гэрийн түлхүүр

-Амьдралын чинь хамгийн анхны дурсамж?
-Долоон настайдаа мотоцикл унаж байсан

-Цүнхэндээ ганцхан зүйл үлдээгээд бусдыг нь хая гэвэл юу авч үлдэх вэ?
-Утсаа авч үлдэнэ

-10 жилийн дараах өөрийгөө хэрхэн төсөөлж байна?
-Бага зэрэг хөгширсөн Амгааг төсөөлж байна /инээв/

-Өөрийгөө амьтантай зүйрлэвэл?
-Мэлхий

-Маргааш дэлхий сүйрнэ гэвэл юу хийж үзэх вэ?
-Шүхрээр бууна

-Өөртөө авсан хамгийн үнэтэй зүйл?
-Орон сууц ■

ХАМГИЙН, ХАМГИЙН

Дэлхийн хамгийн үнэтэй дарс Screaming Eagle Cabernet

Дэлхийн хамгийн үнэтэй дарс 1992 оны Screaming Eagle Cabernet бөгөөд буяны үйлсэд зориулсан дуудлага худалдаагаар 500 мянган ам.долларын үнэ хүрчээ. Олон жилийн турш cabernet дэлхийн хамгийн үнэтэй дарсны жагсаалтыг тэргүүлж байсан бөгөөд энэ амжилтыг 2000 онд тогтоосон аж. Шинэ царс модны анхилуун үнэртэй энэ дарсыг Cisco Systems-ийн захирал Чейз Бейли худалдан авч байжээ. Өнөөг хүртэл эл дарсны үнэ цэн улам бүр нэмэгдсэн бөгөөд амжилтыг нь хараахан эвдээгүй байна. ■

$500.000